

---

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТЭРГҮҮН ТУРШЛАГУУД-1

---

Улаанбаатар хот  
2019 он

- ГАРЧИГ -

<b>МЭНДЧИЛГЭЭ</b> . . . . .	<b>5</b>
<b>МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН</b> <b>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН САЙН ТУРШЛАГУУД</b> . . . . .	<b>8</b>
ЦЭДЭНГИЙН ОЮУНБААТАР: <b>УРСАН ӨНГӨРӨХ ЦАГ ХУГАЦАА</b> <b>ТУТАМД ШУДАРГА ҮЙЛИЙГ БҮТЭЭНЭ ГЭДЭГ ГИШГЭСЭН</b> <b>МӨР ЦАГААН БАЙХ АМЬДРАЛЫН МӨН ЧАНАР ЮМ</b> . . . . .	<b>9</b>
<b>МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН</b> <b>БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО</b> . . . . .	<b>11</b>
ДАМБАДОНДОГИЙН БААТАРЖАВ: <b>2008 ОНЫ БЭЭЖИНГИЙН</b> <b>ПАРАЛИМПИЙН АВАРГА, ХБИ-ЭЭС АНХНЫ ХӨДӨЛМӨРИЙН БААТАР,</b> <b>ГАВЬЯАТ ТАМИРЧИН БОЛСОН НЬ БАХАРХАМ АМЖИЛТ</b> . . . . .	<b>14</b>
БААСТЫН ОРГОДОЛ: <b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ</b> <b>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД СААД БОЛОХГҮЙ.</b> . . . . .	<b>16</b>
Д.БАДАМХАНД: <b>АВИЛГАГҮЙ НИЙГЭМД АЖИЛ</b> <b>МЭРГЭЖЛЭЭРЭЭ ШУДАРГА ӨРСӨЛДЬЕ</b> . . . . .	<b>19</b>
<b>БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ</b> МӨНХБАЯРЫН БАТСАЙХАН: <b>ӨВЧИНДӨӨ ЗАХИРАГДАЖ,</b> <b>ЦАГИЙГ ЗҮГЭЭР ӨНГӨРҮҮЛЖ БОЛОХГҮЙ</b> . . . . .	<b>22</b>
<b>ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ</b> ТҮВШИНХҮҮГИЙН ТУЛГА: <b>АЖИЛТАЙ, ТОГТМОЛ ОРЛОГОТОЙ</b> <b>БАЙВАЛ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БИДЭНД СААД БОЛОХГҮЙ.</b> . . . . .	<b>24</b>
<b>БАЯНГОЛ ДҮҮРЭГ</b> ЮНДЭНГИЙН БАТ-ЭРДЭНЭ: <b>УРЛАГ, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ НЬ</b> <b>СЭТГЭЛ ЗҮЙН БОЛООД БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛД ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ</b> . . . . .	<b>26</b>
<b>СҮХБААТАР ДҮҮРЭГ</b> ЖАМБАЛЖАМЦЫН УСНАКА: <b>СУВИНЕР БҮХЭН</b> <b>ЦАГ ҮЕИЙН ХӨГЖЛИЙН ТҮҮХ ӨГҮҮЛДЭГ</b> . . . . .	<b>28</b>
<b>БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ</b> ДАУИТХАНЫ ХАБЫЛХАТ: <b>"БИ АМЬДРАЛД ХАЙРТАЙ".</b> . . . . .	<b>30</b>
<b>БУЛГАН АЙМАГ</b> ПОЛООЗЫН САРАН: <b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ</b> <b>ИРГЭНД ТОГТМОЛ ОРЛОГО ХАМГИЙН ЧУХАЛ</b> . . . . .	<b>31</b>
<b>ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ</b> ДУЛАМЫН ТҮМЭНДЭЛГЭР: <b>ҮНДЭСНИЙ ХУВЦАСНЫ</b> <b>УРАН ХИЙЦИЙГ ДОЛООН ШАВЬДАА ӨВЛҮҮЛСЭН</b> . . . . .	<b>33</b>

<b>ДАРХАН УУЛ АЙМАГ</b> ЛУВСАНГИЙН ОТГОНДУЛАМ: <b>ГАЗРЫН ШИМ, ХӨДӨЛМӨРИЙН ҮР ХОЁР ХҮНИЙ АМЬДРАЛЫГ ТЭТГЭДЭГ . . . . .</b>	<b>34</b>
<b>ДУНДГОВЬ АЙМАГ</b> НЯМСҮРЭНГИЙН ДАШ: <b>БИЧГИЙН СОЁЛ БОЛ ҮНДЭСТНИЙ ТҮҮХ . . . . .</b>	<b>35</b>
<b>ОРХОН АЙМАГ</b> БЯМБАЖАВЫН ЗАМБАГАЦЭЦЭГ: <b>ХӨДӨЛМӨРЧ ГАР МИНЬ МИНИЙ АМЬДРАЛЫГ “ХӨЛ ДЭЭР НЬ” БОСГОСОН . . . . .</b>	<b>37</b>
<b>ӨВӨРХАНГАЙ АЙМАГ</b> Б.ӨЛЗИЙБАЯР: <b>АЙМАГТАА ШИЛДЭГ АВТЫН ЗАСВАРЧИН. . . . .</b>	<b>38</b>
<b>ӨМНӨГОВЬ АЙМАГ</b> ТУЛГАХҮҮГИЙН БАРХАС: <b>БИЧИГ ҮСЭГ БҮРЭН СУРАХ НЬ ХАРИЛЦААНД ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ . . . . .</b>	<b>39</b>
<b>ТӨВ АЙМАГ</b> ЧОЙЖИЛЗАВЫН ПҮРЭВБАЗАР: <b>ИРГЭДИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ НЬ ТЭДЭНД ҮЗҮҮЛЖ БАЙГАА ХАМГИЙН ТОМ ТУС . . . . .</b>	<b>40</b>
<b>ХОВД АЙМАГ</b> ПҮРЭВИЙН ИДЭР: <b>ХӨДӨЛМӨРЧ, СЭТГЭЛИЙН ТЭНХЭЭТАЙ БАЙХАД АМЬДРАЛ БҮТЭН БОЛДОГ. . . . .</b>	<b>41</b>
<b>ХЭНТИЙ АЙМАГ</b> ЧАДРААБАЛЫН БАТБИЛЭГ: <b>МАЛЧ МОНГОЛ УХААН НАМАЙГ НАСААР МИНЬ ТЭТГЭЖ ЯВНА . . . . .</b>	<b>42</b>
<b>ДОРНОГОВЬ АЙМАГ</b> ДОРЖГОТОВЫН ТҮВШИНДЭЛГЭР: <b>МИНИЙ АЖИЛ ХАМГИЙН СОНИРХОЛТОЙ БАС ХЭЗЭЭД ОРХИГДОХГҮЙ МЭРГЭЖИЛ . . . . .</b>	<b>43</b>
<b>СҮХБААТАР АЙМАГ</b> АЮУРЗАНЫН БАТБАЯР: <b>ХҮМҮҮСТ АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХИЙГ ХИЧЭЭЖ БАЙНА . . . . .</b>	<b>44</b>
<b>БАЯНХОНГОР АЙМАГ</b> БАТМӨНХИЙН ЯНЖИНДУЛАМ: <b>ОЁДОЛ ЭСГҮҮРТ ХҮНИЙ ГАРЫН УРААС ГАДНА УХААН ШИНГЭСЭН БАЙДАГ . . . . .</b>	<b>45</b>
<b>УВС АЙМАГ</b> АХМАД ТАМИРЧИН О.ТӨМӨРСАНАА: <b>АЙМГИЙНХАА ШИГШЭЭ БАГИЙГ ДАСГАЛЖУУЛДАГ. . . . .</b>	<b>46</b>
<b>ГОВЬСҮМБЭР АЙМАГ</b> И.БААТАР: <b>БИ ҮРГЭЛЖ ИНЭЭДЭГ БОЛСОН... . . . .</b>	<b>47</b>

<b>ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН</b> <b>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН САЙН ТУРШЛАГУУД . . . . .</b>	<b>48</b>
1. JASS (НЭР ДЭВШСЭН) <b>СТЕВАРТС КЕЙР БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ҮЗҮҮЛСЭН</b> <b>ДЭМЖЛЭГТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ . . . . .</b>	<b>49</b>
2. KARE ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХӨТӨЛБӨР (НЭР ДЭВШСЭН) <b>СЭТГЭЦИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН</b> <b>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ НЬ. . . . .</b>	<b>50</b>
3. БОДИТ БОЛОМЖ - ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД ШИЛЖИХ НЬ (НЭР ДЭВШСЭН) <b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙГ МЭРГЭЖЛИЙН</b> <b>ТУРШЛАГА ЭСВЭЛ ЦАЛИНТАЙ АЖЛААР ХАНГАХ НЬ . . . . .</b>	<b>51</b>
4. EINER FUR ALLE - НЭГ НЬ НИЙТИЙН ТӨЛӨӨ <b>НЭГ НЬ НИЙТИЙН ТӨЛӨӨ - ОРОН НУТГИЙН</b> <b>НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДЭЛГҮҮР . . . . .</b>	<b>52</b>
5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙГ АЖИЛ ХӨДӨЛМӨРТ ОРОЛЦУУЛАХ НЬ <b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДАД</b> <b>ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ ДИЗАЙН . . . . .</b>	<b>53</b>



## МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм уншигч таны гарт “Хөдөлмөр эрхлэлтийн сайн туршлага” эмхэтгэл хүрэлцэн очих билэгт сайн өдрийн мэндийг хүргье.

Монгол улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд ажиллах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг байгуулсан. Бид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар Төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах, салбар дундын уялдаа холбоо, хамтын

ажиллагааг шинэ шатанд гаргах, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, эрүүл мэнд, нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг чанарын өндөр түвшинд хурдан шуурхай, хүртээмжтэй хүргэх, боловсролд тэгш хамруулах, тохируулгат ажлын байрыг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх, чадавхижуулах зэрэг томоохон зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Бид Европын холбооны SECiM төсөлтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, нийгэмд хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг ойлголт хандлагыг төлөвшүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж 2019 оны байдлаар 100 гаруй иргэдийг ажлын байранд зуучилж, 200 гаруй ААНБ-д нөлөөллийн ажлыг зохион байгуулсан билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал бол зөвхөн манай улсад тулгамдаж буй асуудал биш билээ. Дэлхийн өнцөг булан бүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэд харилцан адилгүй ажиллаж амьдран нийгэмдээ өөрийн гэсэн оролцоотой нийгмийн загварыг бий болгож байна. Улс орны хөгжил, хэрэгжиж буй хууль эрх зүйн хувьд ялгаатай улсад бид амьдардаг ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн маань ахуй амьдрал, тэдний нийгэм дэх бие даасан оролцоог бодит болгох нь манай улсын хувьд тулгамдаж байгаа асуудал юм. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн тэргүүн туршлагуудыг нэгэн номонд багтаан иргэн танд

шинийг санаачлах, өөрт байгаа боломжоо нээх, итгэл, урам зориг хайрлах, бусадтай мөр зэрэгцэн хийж бүтээх үйлсийн гараа болно хэмээн найдаж Та бүхэндээ өргөн барьж байгаадаа туйлын баяртай байна.

Монгол орны өнцөг булан бүрт амьдран суугаа иргэддээ чин сэтгэлийн мэндчилгээний хамт амьдралд нь аз жаргал хүсэн, санасан хэрэг бүхэн нь сэтгэлчилэн бүтэж, санаачлага болгон нь ажил болон жавхаажиж, үйлс нь өөдөө, амьдрал нь өөдрөг байхыг хүсэн ерөөе.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНЧИМЭГ

## МЭНДЧИЛГЭЭ



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Монгол улсын болон Европын Холбооны сайн туршлагыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран хэвлүүлж байгаадаа Европын Холбооны санхүүжилттэй “Монгол улсад ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” SECiM төслийн багийн ахлагчийн хувьд би туйлын их баяртай байна. Эдгээр сайн туршлага, загвар нь бидэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон сайн ажлын байр бий болгох аргуудыг харуулах юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүр адилгүй. Тэдний бэрхшээл бие бялдрын, мэдрэхүйн эрхтний, оюуны болон сэтгэцийн шинжтэй байдаг. Хөгжлийн бэрхшээл төрөлхийн, хүүхэд насанд, өсвөр насанд болон амьдралын хожуу үе буюу боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхлэх үед ч олдсон байдаг. Хөгжлийн бэрхшээл нь тухайн хүний хөдөлмөрлөх, нийгэмшихэд бага нөлөө үзүүлдэг явдал байдаг. Эсрэгээрээ маш их нөлөө үзүүлдэг бөгөөд дэмжлэг, туслалцаа шаардах нь ч бий. Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил, хөдөлмөрийн бүхий л түвшинд ажиллаж хувь нэмрээ оруулж байна. Гэхдээ л ажил, хөдөлмөр эрхлэхийг хүсэж байгаа ч олон саад бэрхшээлийн улмаас хөдөлмөрлөж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон байна.

Энэхүү эмхэтгэлд дурдагдсан бүх байгууллагад би халуун баяр хүргэхийн ялдамд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг дэмжиж ажилладаг Монгол улсын төрийн байгууллагууд, хувийн хэвшлийн ажил олгогчид болон бусад байгууллагуудыг энэхүү амжилтаас урам, санаа аван ажиллахыг уриалж байна.

ТӨСЛИЙН БАГИЙН АХЛАГЧ



АГРИТА ГРОЗА

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН  
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН  
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
САЙН ТУРШЛАГУУД**



**ЦЭДЭНГИЙН ОЮУНБААТАР: УРСАН ӨНГӨРӨХ ЦАГ ХУГАЦАА  
ТУТАМД ШУДАРГА ҮЙЛИЙГ БҮТЭЭНЭ ГЭДЭГ ГИШГЭСЭН  
МӨР ЦАГААН БАЙХ АМЬДРАЛЫН МӨН ЧАНАР ЮМ**



Цэдэнгийн Оюунбаатар 1959.07.16-нд Хэнтий аймгийн Биндэр суманд төрсөн. Эрдэм номын гараагаа төрөлх сумаасаа эхэлж, 1982 онд ХААИС-ийн механик инженерийн ангийг дүүргэжээ. Тэрээр 1982 оноос Дорнод аймагт ХАА-н ТМС-д багшаар ажиллаж, хөдөлмөрийн гараагаа эхэлсэн байна. 1986 онд Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэнд секторын эрхлэгчээр ажиллаж байгаад мэргэжлээ ахиулан мэргэшиж, 1987 онд “Эд ангийн элэгдлийн судалгаа” сэдвээр техникийн ухааны магистр, 1993-2000 ШУТИС-д багш, 2002-2004 онд “Автомашинь эд ангийн трибологийн судалгаа” сэдвээр ШУТИС-ийн докторантур төгссөн. 2001-2008 он Монгол-Солонгосын Техникийн Коллеж-д багшилж байсан. Тэрээр ажлынхаа хажуугаар сонгуульт ажил эрхлэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр дагнан ТББ-аараа дамжуулан үйл ажиллагаа явуулж ирсэн. Оюунбаатар нь 2004 оноос хойш Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбооны ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Тэрээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын чиглэлээр хэд хэдэн хуулийн төсөл боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэж ажилласан билээ. Энэ чиглэлээр одоо ч ажилласаар байгаа тэрээр 3 хүүхдийн аав, 4 зээгийн өвөө юм.





### **Бүтээлүүд**

#### **Сонгуульт ажлын туршлага:**

- 1993-2004 он Монголын Ажил Хэрэгч Тахир Дутуу Иргэдийн Холбооны тэргүүн
- 2004 оноос одоог хүртэл МХБИБҮХолбооны ерөнхийлөгч
- 2004-2008 он Хүний Эрхийн Үндэсний Комиссын орон тооны бус зөвлөлийн гишүүн
- 2004-2008 он Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн сайдын зөвлөлийн гишүүн
- 2004-2007 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн ажлын хэсгийн ахлагч
- 2005 оноос ММССангийн оролцогч талуудын хорооны гишүүн, Удирдах зөвлөлийн гишүүн
- 2008 оноос Иргэний Нийгмийн Зөвлөлд зөвлөх
- 2012 оноос Инчеоны стратегийн Ази Номхон далайн промоутер

#### **Нөлөөлөл хийж батлуулсан хуулиуд:**

- 1998 онд Хөдөлмөрийн хуулинд “ХБИргэдийг” хөдөлмөр эрхлүүлэх тухай 111-р заалт оруулсан
- 2003 онд Хөгжлийн Бэрхшээлтэй нэр томъёог хэрэглэх хуулийн өөрчлөлт
- 2006 онд ХБИргэдийн Үндэсний хөтөлбөр
- 2007 онд Биеийн Тамир Спортын, Татварын зэрэг 7 хуулинд өөрчлөлт
- 2008 онд Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Нийгмийн Хамгааллын тухай хууль
- 2008 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, нэмэлт протоколын хамт
- 2009 онд Мэргэжлийн боловсролын тухай хууль
- 2016 “Хөгжлийн бэрхшээлтэй хүний иерхийн тухай хууль

## Бүтээлүүд

- “Эд ангийн элэгдлийн судалгаа” сэдвээр магистрын ажил 1998 он
- 2002-2004 онд “ Автомашинны эд ангийн трибологийн судалгаа” докторын ажил
- Гагнуурын технологи ном 2004 он
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гарын авлага 2008 он
- Нийгмийн хариуцлагын аргаар нийтийн тээврээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих боломжид хийсэн мониторингийн тайлан 2009 он
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн шалгуур үзүүлэлт боловсруулах судалгаа 2010 он
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн төлөв байдалд хийсэн судалгаа 2010 он
- Хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн хандлагаар тодорхойлох аргачлал 2011 он

## МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО



Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо нь 1997 онд байгуулагдсан. Хараа, сонсгол, хэл яриа, нуруу нугасны бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 12 байгууллагын санаачилгад суурилан тус байгууллагыг үүсгэн байгуулжээ. Өдгөө Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо нь Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт салбар зөвлөлтэй, хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн 44 байгууллагыг гишүүнээр элсүүлэн нэг зорилгын дор хамтран ажиллаж байна. Холбооны дэргэд “Мөнх тэнгэр” студи ажилладаг.

Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбооны эрхэм зорилго нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүх төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих, Монгол улсын нутаг дэвсгэрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар нэгдсэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх”-д оршино.



Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо нь үндсэн гурван чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн эрхийн асуудлаар төрийн бодлого, шийдвэр гаргалтад нөлөөлөх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжинд хяналт тавих
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг төрийн бус байгууллагуудын ур чадвар, чадавхийг дээшлүүлэх.

Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо нь Ази, Европ, АНУ зэрэг орны байгууллагатай түншийн харилцаатай ажилладаг. Мөн тус холбоо нь Тайландын Бангкок хотноо төвтэй Ази номхон далайн бүсийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Төвийн гишүүн байгууллага юм.

Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо нь өнгөрсөн хугацаанд дараах ажлуудыг хийжээ.

### **Төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөх чиглэлээр:**

- 1998 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах зорилгоор “50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгжүүд нийт ажиллагсдынхаа 3 хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүн авч ажиллуулах заалтыг “Хөдөлмөрийн тухай” хуулинд оруулсан. 2007 онд уг заалтыг “25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгжүүд нийт ажилтныхаа 4 хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүн авч ажиллуулахаар” өөрчлөлт оруулж батлуулсан.
- 2001 оныг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих жил болгон зарлуулсан.
- 2003 онд “Тахир дутуу” гэсэн нэр томъёог “Хөгжлийн бэрхшээлтэй” гэсэн нэр томъёогоор солих шийдвэр гаргуулсан.
- 2004 онд Монгол Улсын Их Хуралд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих “Лобби” бүлэг байгуулан Улсын Их хурлаас гарах шийдвэрт нөлөөлж ажилласан.
- 2006 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор ХБХүний эрхийн асуудлаар үндэсний чуулганыг зохион байгуулж чуулганаас Төрийн болон Бизнесийн байгууллагад хандсан зөвлөмж гарган хэрэгжилтэд анхааран ажилласан.
- 2006 онд ХБИргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр, ХБХүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг Засгийн газраас батлуулсан.



- 2007 онд ХБИргэдийг бусадтай адил байх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс салбарын 7 хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар саналаа УИХ-д өргөн барьж батлуулсан.
- 2008 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 61-р чуулганаар батлагдсан ХБХүний эрхийн тухай конвенцийг, нэмэлт протоколын хамт УИХ-аар соёрхон батлуулав.
- 2014 онд НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай” конвенцийн сүүдэр тайлан бичихэд манлайлан оролцож, Засгийн Газарт НҮБ-ын хүний эрхийн хорооноос өгөх зөвлөмжийн эхийг боловсруулсан.
- 2014 онд “Хүүхдийн эрхийн тухай” конвенцийн сүүдэр тайлан бичихэд оролцсон.
- 2015 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай” хууль боловсруулахад оролцож, Улсын Их хуралд батлуулахаар өргөн барьж батлуулсан.
- 2015 онд “ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, оролцоог дэмжих” үндэсний хөтөлбөр боловсруулахад оролцсон. “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” конвенц, “Нийгэм соёлын эрхийн тухай” олон улсын пактын сүүдэр тайлан бичихэд оролцсон.
- 2016 онд Ерөнхий сайдын болон нийслэлийн засаг даргын дэргэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон тооны бус зөвлөл байгуулж бүрэлдэхүүнд нь орж ажиллаж байна.
- ХНХЯаманд хэрэгжиж байгаа ЖАЙКагийн санхүүжилттэй төслийн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.



## ДАМБАДОНДОГИЙН БААТАРЖАВ: 2008 ОНЫ БЭЭЖИНГИЙН ПАРАЛИМПГИЙН АВАРГА, ХБИ-ЭЭС АНХНЫ ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, ГАВЬЯАТ ТАМИРЧИН БОЛСОН НЬ БАХАРХАМ АМЖИЛТ



Дамбадондог овогтой Баатаржав нь Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрээн хороонд 1961-06-02нд төрсөн. Улаанбаатар хотноо ЕБС-ийн 57-р сургуулийг 1978 онд дүүргэжээ. Тухай үеийн ЗХУ-н Оренбург хотын Барилга Архитекторын сургуульд элсэн суралцсан боловч IV курсээс эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдөж, группт орсон байна.

1984 онд ХНХЯ-ны протезын үйлдвэрт орж, протезын мэргэжил эзэмшин бригадын дарга хүртэл ажилласан байна. 1986 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэн Баярмагнайтай хамтран Монголын Тахир Дутуу Иргэдийн Нийгэмлэгийг санаачлан байгуулжээ.

1989 оноос спортоор хичээллэж 1994 онд Монголын Үндэсний Шигшээ Багийн тамирчин, дасгалжуулагчаар ажиллан ажиллах хугацаандаа Ази Номхон Далайн Бүсийн Орнуудын ХБИ-н олимпын наадамд 5 удаа оролцож Алт, мөнгө, хүрэл медалийн эзэн болсон юм. Тэрээр 2004 оны Ази тивийн аварга, 2000 Сиднейн паралимпын 5-р байр, 2004 Афины паралимпын 4-р байр, 2016 онд Рио Де Жанейро хотноо болсон паралимпын 4-р байрт тус тус шалгарч, 2008 оны Бээжингийн Паралимпын аварга болсноор Монгол улсын 3 дахь Олимпын аварга ХБИ-ээс анхны Хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин болсон бахархам амжилтын эзэн билээ.

Тэрээр 2009 онд сүлжээний байгууллагын санаачилгаар Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Нэгдсэн Холбоог байгуулж өнөөг хүртэл ХБИ-н эрхийг хангахын төлөө тууштай ажиллаж байна. УИХ-ын гишүүдийн дэмжлэгтэйгээр ХБХЭТухай хууль, Ерөнхий сайдын дэмжлэгтэйгээр 2018 онд ХБХХЕГазрыг байгуулахад болон ерөнхий сайдын дэргэд ХБИ-ийн орон тооны бус зөвлөл, бүх яамдын төрийн нарийн бичгийн





даргаар ахлуулсан ХБИ-ийн зөвлөлүүдийг байгуулахад дуу хоолойгоо өргөн төрийн бодлого, шийдвэрт ХБ-тэй иргэдээ төлөөлөн хувь нэмрээ оруулсан юм.

Д.Баатаржав нь Монголын Тахир Дутуу Иргэдийн Спортын Холбоо, Монголын Үндэсний Паралимпын хороо, Монголын Парабайт Харвааны Холбоо, Байт харваачдын “Таван Сум”, “Добу Мэргэн” клубуудыг санаачлан байгуулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг Тив, дэлхийн тэмцээнүүдэд амжилттай оролцож, Алт, Мөнгө, Хүрэл медаль хүртсэн тохиолдолд халамжийн мөнгийг тухайн төрлийн давтамжийн хугацаанаас хамаарч нэг удаа олгодог байх, Паралимпын наадмаас алт, мөнгө, хүрэл медаль авсан тохиолдолд бусад эрүүл тамирчдын нэгэн адил мөнгөн шагнал авдаг байх асуудлыг хөндөн тавьж, хэрэгжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг спортод татан оруулж, спортын дэд мастер, спортын мастер, Олон улсын хэмжээний мастер тамирчдыг бэлтгэн сургаж тив, дэлхийн тэмцээнүүдэд амжилттай оролцуулан алт, мөнгө, хүрэл медалиудын эзэд болгосон. Тэрээр дасгалжуулагчийн хувиар паралимпын наадамд гурван тамирчинг оролцуулж, одоо Токио 2020 паралимпын бэлтгэлд гараад байна.



## БААСТЫН ОРГОДОЛ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД СААД БОЛОХГҮЙ



Баастын Оргодол 1969 оны 3 сарын 20 нд төрсөн. Хүйн халдвараар хүндээр өвдөж хөл, гар, хэл, чих муудаж, улмаар хөгжлийн бэрхшээлтэй болсон. Тэрээр хүний зэрэгтэй амьдрах хүслээр сэтгэл оюунаа дайчилж, Эрүүл мэндийн яамны харъяа байсан “Эрүүл энх” сонинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ талаар мэдээ, сурвалжлага бичиж, нийтэлж байгаад улмаар МУИС-ийн сэтгүүл зүйн ангийг 2002 онд төгсөж, 2009 онд магистрийн зэрэг хамгаалсан юм.

Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн төв хэвлэл “Хүмүүн заяа” сонинг 2001 оноос эрхлэн гаргаж эхэлсэн. 2005 онд телевизийн “Тулга тав” студи болгон өргөжүүлэн хөгжүүлсэн. Тус студийн зорилго нь Монголын 100 мянга гаруй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалж, нийгмийн амьдралд тэгш эрхтэйгээр оролцоход нь туслах, тэдний ажиллаж хөдөлмөрлөх авъяас чадварыг олон түмэнд таниулах, эрүүл хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэхэд санамж зөвлөгөө өгөх, ХБИ-ийг ойлгож дэмжиж тусалдаг хувь хүн болон байгууллагуудыг олон түмэнд сурталчлах, төрөөс баримтлах бодлого шийдвэр, хууль тогтоомжийг таниулах юм. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх нийгмийн сэтгэл зүй, хандлагыг өөрчлөхөд эрхэм зорилго нь оршдог байна.

“Тулга тав” студи нь одоогийн байдлаар 400 гаруй телевизийн нэвтрүүлэг, 12 баримтат кино, 113 гаруй сургалт, семинар, хэлэлцүүлгийн видео нэвтрүүлэг хийж,

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ 主办单位:

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ  
САНХҮҮГИЙН ЯАМ  
САНХҮҮГИЙН ГАЗАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН АГЕРТЛАТ  
УРЬДЧИЛАН ХӨГЖИЛЭЙН ЭРХЛЭЛТИЙН ХҮҮНИЙ ЗӨГШӨЛӨН ЕРӨНХИЙ ГАЗАР  
СНС  
大鸾翔宇 Enlai Foundation  
中国友好和平发展基金会 China Friendship Foundation for Peace and Development

**“НАЙРАМДЛЫН ХОНХ”**  
САЙН ҮЙЛСИЙН АЯН  
“风铃行动” 善公益活动

ДЭМЖИГЧ БАЙГУУЛАГА 支持单位:  
● МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ  
● БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИЙН САЙДЫН ЯАМ  
● БНХАУ-ЫН ЧИХНИЙ ЭМЧ НАРЫН ХӨГЖЛИЙН САН  
● 中国听力医学发展基金会  
● БНХАУ-ЫН ХУАМНН САН  
● 中国华夏慈善基金会

ТРАГЧ БАЙГУУЛАГА 协办单位:  
● Хятадын Найрамдлын Нийгэмлэг  
● Хятадын Бизнес Эрхлэгчдийн Зүүн Хүр  
● ТС ГРУПП  
● Н НЭГДСЭН ХОЛБОО



байнгын хамтын ажиллагаатай телевизүүд болох МҮОНРТ, MN-25, UBS, TV5 ,SBN - телевизүүдтэй гэрээт хуваарийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашиг, хүсэл сонирхол, амжилт бүтээл, тэмүүлэл зорилгыг харуулсан дэлгэцийн бүтээлүүдээ үзэгч олондоо хүргэсээр байна.

2008 онд Бээжингийн паралимпоос анхны аваргатай болсон алтан агшинг сурвалжилсан цорын ганц студи нь “Тулга тав” бөгөөд “Эрч хүч дагуулсан аварга” нэвтрүүлэг хийж, үзэгч олондоо хүргэжээ. Мөн 2010 онд Гуанжоугийн Азийн пара наадмаас манай баг тамирчид 2 мөнгө, 3 хүрэл медаль авсан торгон агшинг харуулсан 2 нэвтрүүлэг, 2014 оны БНСУ-ын Инcheonий Азийн пара наадмаас 2 алт, 1 мөнгө, 8 хүрэл медаль авсан талаар 2 нэвтрүүлэг, БНСУ-ын Сөүл хотод болсон Дэлхийн хараагүйчүүдийн их наадам “IBSA”-аас 2 нэвтрүүлэг, АНУ-ын Лос-Анжелес хотод болсон Оюуны бэрхшээлтэй хүмүүсийн тусгай олимпод анх удаа Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцсон талаар нэвтрүүлэг тус тус хийсэн байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд МҮОНРТ, MN25, UBS телевизтэй сард нэг удаа, TV5, SBN телевизтэй улиралд нэг удаа 20-30 минутын нэвтрүүлгийн цацалтын гэрээтэй ажиллаж байна. Тэрээр ярихдаа:

“Монгол улсад одоогийн байдлаар 60 гаруй телевиз, 30 гаруй вэб сайт, 30 гаруй FM радио, өдөр тутмын 14 сонин, улирал тутам хэвлэгддэг 30 гаруй сонин, сэтгүүл үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр телевиз, FM, радио, сонин сэтгүүлүүд нь өдөр тутам үйл ажиллагаа явуулдаг боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх, тэдний талаарх зөв хандлага руу олон нийтийг чиглүүлсэн нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх эдгээр иргэдийн эрх, тулгамдаж буй асуудлыг хөндөж гаргах тал дээр хангалтгүй байна.



Анх сургуульд орох болоход намайг ийм хүүхдийг сургах ямар ч боломжгүй гээд аваагүй. Би гурав хоног уйлж, аав маань 63 дугаар тусгай сургуульд “арын хаалга”-аар оруулж байсан. Хэрвээ ийм сургууль байгаагүй бол би өдийд ингэж явахгүй байсан.

Хүмүүсд өвчин хэлж ирэх биш дээ. Харин сэтгэлийн тэнхээгээр хорвоог туулах хэрэгтэй. Өөртөө итгэлтэй, хүсэл мөрөөдөлтэй байх хэрэгтэй гэж би хүүхэд залуучууддаа хэлдэг. Хүмүүс зураг аваад бичлэг хийгээд тэр нь нэвтрүүлэг болдог гэж ойлгодог. Зарим уран бүтээлчид нэвтрүүлгээ үзэгчдийн сэтгэлийг эмзэглүүлэх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй биднийг ядарсан өрөвдөлтэй болгож харагдуулахыг хичээдэг. Зориуд хэлмээр санагдаж байна.

Жишээ нь намайг цай ууж байхад хүний нүдэнд эвгүй харагдах өнцгөөс нь харуулахаар үзэгчид энэ ямар өрөвдмөөр юм бэ юун нэвтрүүлэг хийх аягатай цайгаа ууж чадахгүй байна шүү дээ гэж бодно. Зарим нь эрүүл хүмүүсээс илүү юм шиг худлаа магтаж, нэвтрүүлгээ хийдэг, энэ нь нийгмийн сэтгэхүйг өөрчлөх биш, харин олон арван хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын амьдрах итгэл урам зоригийг мохоох сөрөг үр дагавартай байдгийг тэр болгон хүмүүс мэддэггүй нь харамсалтай...” гэж байлаа.

Оргодол гуайн хэлэх дуртай үг нь баярлалаа.

- Та яагаад байнга баярлалаа гэж хэлдэг юм бэ гэж асуухад

- Намайг хаа явсан газар хүн бүхэн надад тусалж хүндэтгэж байдаг. Би энэ их ачийг баярлалаа гэж хариулахаас өөр яах вэ дээ гэж хэлдэг юм.

Одоо телевизүүд нь тоон систем буюу HD форматаар нэвтрүүлгүүдээ цацах цаг үеийн хөгжлөө дагасан шаардлага бий болсон. Тиймээс ч мэргэжлийн түвшинд сайн нэвтрүүлэг хийх зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм. Телевизийн нэвтрүүлэг хийхэд зайлшгүй мэргэжлийн сэтгүүлч, зураглаач, монтажчин, хөтлөгч байх шаардлагатай учраас “Тулга тав” студи нь залуу боловсон хүчин бэлтгэхэд анхааран ажиллаж байна.

Мөн МҮОНТ-д тогтмол сардаа нэг удаа хүмүүн заяа нэртэй нийгмийн асуудал хөндсөн цуврал нэвтрүүлэг гаргахаар бэлтгэл ажилдаа шамдан ороод байна. Түүний хөдөлмөр, зүтгэлийг үнэлэн 2008 онд эрүүл мэндийн яамны жуух бичиг, 2011 онд ХНХЯ-ны хүндэт жуух бичиг, 2012 онд нийслэлийн тэргүүний ажилтан цол тэмдэг, 2013 онд хөдөлмөрийн хүндэт медаль, 2014 онд Алтан гадас одонгоор тус тус шагнажээ.



## Д.БАДАМХАНД: АВИЛГАГҮЙ НИЙГЭМД АЖИЛ МЭРГЭЖЛЭЭРЭЭ ШУДАРГА ӨРСӨЛДЬЕ



Д.Бадамханд нь 1985 онд дунд сургуулиа төгсөөд МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуульд элсэн суралцаж 1992 онд дүүргэжээ. Багш-сэтгүүлч мэргэжилтэй тэрээр 1992 онд МУИС-ийн анхны магистрантурт элсэн суралцаж, 1994 онд хэл шинжлэлийн ухааны магистр зэрэгтэй төгсжээ. Удирдлагын академийн нийгмийн ухааны салбарт 2006 онд Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын Үндэсний

холбоо болон Италийн “Айфо” байгууллагаас хамтран хэрэгжүүлсэн ТББ-уудын удирдагч, манлайлагчдыг чадваржуулах зорилгоор хэрэгжүүлсэн богино хэмжээний эрчимжүүлсэн сургалтад хамрагдаж, 2010 онд АНУ-ын Төрийн Департаментын шугамаар Олон улсын солилцооны хөтөлбөрт хамрагдаж, туршлага судлан мэргэшлээ дээшлүүлсэн.

Уран бүтээлээ 1978 оноос эхлэн туурвиж, анхны номоо 2005 онд “Итгэл сэтгэл” нэртэйгээр хэвлүүлж, дууны урын сангаараа анхны тоглолтоо үзэгч түмэндээ толилуулсан. МУУГЗ хөгжмийн зохиолч Б.Долгионтой хамтран “Дэгдээхэйн жигүүр гүйцэх боллоо” анхны дуугаа 1983 онд зохиосон. Түүний шүлгүүдэд Монголын нэрт хөгжмийн зохиолчид аялгуугаа хийсээр өдгөө рок, поп урлагийн мастерууд урын сангаа баяжуулж, олны хүртээл болгосоор байна.

Тэрээр 1994 онд Улсын түүхийн төв архивт хэсэг хугацаанд манж





хэлний архивчаар ажиллаж байгаад “Амьдралын тойрог” нэртэй мэдээлэл, танин мэдэхүй, уран сайхны сониныг 1995 онд санаачилан үүсгэж, 2000 он хүртэл 5 дугаарыг хэвлүүлэхдээ нийтлэлийн бодлогодоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тусгаж, олон нийтийн хандлагыг эерэг болгох, тэдний авьяас чадварыг сурвалжлан таниулсаар ирсэн байна. 1998-2000 онд Олон улсын дэмжлэг туслалцаа, төлөөлөгчийн газрын санхүүжилтээр Монголын радиогийн сургалт танин мэдэхүйн редакцтай хамтран “Бид та нарыг мартаагүй, мартахгүй” нэвтрүүлгийн хөтөлгөч, редактораар ажиллаж байсан.



Д.Бадамханд 1997 онд “Өнөөдөр” сониноос Монголын хэвлэлийн магнат Ц.Балдорж эрхлэгчийн дэргэдээс ажлын гараагаа эхэлсэн хэмээн ярьдаг. Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо үүсэн байгуулагдахад хэвлэл

мэдээллийн албыг шинээр зохион байгуулж, удирдан 1997-2007 онд хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албыг хашиж байв.

2004-2008 онд УИХ дахь “Лобби” бүлгийн гишүүдтэй Үндэсний холбооны нэрийн өмнөөс хамтран ажиллаж, УИХ-аар хэлэлцэгдэж байгаа хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой 7-9 хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахад бодитой хувь нэмрээ оруулсан сэтгүүлч хүн юм. Улмаар 2003 оноос “Салхич шувуу” ТББ-ыг үүсгэн байгуулж, Удирдах зөвлөлийн дарга бөгөөд захирлаар нь ажиллахдаа “Шинэ долгион 107.5” радиогийн эфирт “Амьдралын тойрог” нэртэй нэвтрүүлгийг бэлтгэн хөтөлж байсан. Уг нэвтрүүлгээрээ хөдөлмөр эрхэлж, амьдралаа хэнээс ч дутахгүй авч яваа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэднийг ажлын байраар хангаж, хүнлэг сэтгэлээр хандаж байгаа энэрэнгүй үйлстэнд талархаж, ая дууны мэндчилгээ илгээн итгэл сэтгэлийн гүүр болдог байжээ. Тэрээр Боловсрол суваг телевизд 2008-2011 онд ажиллахдаа “Бидний нэг” теле сэтгүүлийг хөтлөн явуулж байгаад 2017 оноос эхлэн МҮОНТ-ийн редактораар ажиллаж, “Миний тэмдэглэлүүд” зорилтот нэвтрүүлгийг хариуцан ажиллаж байна.

Хүн бүхэн өмнөө тавьсан зорилготой, өсөж дэвжих хүсэл тэмүүлэлтэй байх нь хамгийн гол тулгуур хэмээн үздэг Д.Бадамханд хүүхэд залуучуудын “Оюуны элч” клубыг “Салхич шувуу” төвийн дэргэд 2010 оноос эхлэн халамжилж, хамтран ажиллажээ. Хамтын ажиллагаа чамлахааргүй үр дүнг авчирсан. Одоо тэд сурах сургууль, ажлын хамт олонтой, амьдралдаа сайн хань, үр хүүхдүүдтэй ч болж хүний хорвоогийн баяр гунигийг бас мөрөөдөлдөө хүрэхийн сайхныг мэдэрч явна.

2010 онд тэрээр Америкт “Хөгжлийн төлөө хамтдаа” уриатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд, сэтгүүлчдийн танилцах аяллыг амжилттай зохион байгуулсан. Үүнийг онцолж, 2011 онд АНУ-ын 44 дэх Ерөнхийлөгч Барак Обама Цагаан Ордоноос Д.Бадамхандад хаягласан Талархлын захидал илгээж байсан байна.

Багш-сэтгүүлч Д.Бадамханд нь 1998 онд Монголын залуучуудын холбооны “Тэргүүний залуу” алтан медаль, 2010 онд МСНЭ-ийн шагнал “Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан”, 2013 онд Нийгмийн хамгааллын тэргүүний ажилтан, 2015 онд МУ-ын Соёлын тэргүүний ажилтан, 2019 онд МСНЭ-ийн “Ган үзэгтэн” цол тэмдгээр тус тус шагнагдсан нь түүний нөр их хичээл зүтгэл, бахархам амжилт билээ.

2019 онд Д.Бадамханд “Босох тэнхэл” нэртэй өөрийн намтар, уран бүтээл, аян замын тэмдэглэл, амьдралын замнал гээд оюун санаандаа хураан эвхсэн дурсамжаа дэлгэсэн шинэхэн номоо хэвлүүлэн гаргажээ. Чухам түүний энэхүү номонд өгүүлэх өөрийн намтар, хувь тавилангийн ээдрээт гогцоо уншсан хүн болгонд сургамж, ухаарал, туршлага, ирээдүйг дэнслэн итгэл өвөрлөн “Босох тэнхэл” хайрлах бүтээл болсон байна.


Хүн бүхэнд ажил амьдралын туршлага, бас ажиллаж амьдрах зарчим гэж байдаг. Түүний зарчим бол “авилгагүй орчинд ажил мэргэжлээрээ шударга өрсөлдөх, бусдын итгэлийг дааж явах шиг сайхан юм хаана байх билээ. Олз ашгинд шунахгүй, олсон мэдээллээ нөгөөдөө хүргээд олуулаа эвтэй, найртай явцгаахад очиж хүрэхгүй орон, орж чадахгүй газар, ойшоож сонсохгүй хүн байх уу?” гэж тэр хэлдэг. Амьдралын олон нугачааг туулсан өөртөө итгэлтэй хүний үг энэ бизээ.



## БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ



Багахангай дүүрэг нь 1992 онд байгуулагдсан. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос зүүн урагш 90 км-т, оршдог. 14.0 мянган га нутаг дэвсгэртэй, засаг захиргааны 2 хороотой. Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн нэг юм. 1045 өрхийн 3724 хүн ам оршин суудаг. 2018 оны статистик мэдээгээр дүүрэгт 152 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 23 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүртгэлтэй байна. Энэ нь тус дүүргийн нийт хүн амын 4 хувийг ХБИ-д эзэлж байна гэсэн үзүүлэлт юм.



### МӨНХБАЯРЫН БАТСАЙХАН: ӨВЧИНДӨӨ ЗАХИРАГДАЖ, ЦАГИЙГ ЗҮГЭЭР ӨНГӨРҮҮЛЖ БОЛОХГҮЙ



Мөнхбаярын Батсайхан нь 1975 онд Улаанбаатар хотод төрсөн. 1993 онд нийслэлийн 69-р дунд сургуулийг төгссөн. 10-р ангиа төгсөөд хөрш айлын Д.Лувсандоржоор заалган хүнсний ногоо тарьж эхэлжээ. Ажил хийж эхлэхэд газар шороо ухаж, ногоо тарина гэдэг хэцүү байсан ч хөдөлмөрлөх хүсэлдээ хөтлөгдөн хашаандаа өөрийнхөө хэрэгцээний ногоог

тарьж, цөхрөлтгүй тордон намар нь арвин ургац хурааж хөдөлмөрийн амтанд орсон байна. Тэр цагаас хойш хашааныхаа газрын талыг хагалж тарих ногооныхоо нэр төрлийг олшруулан хэрэгцээнээсээ илүү гарсан хүнсний ногоог зарж борлуулдаг болов. Улмаар зэргэлдээ амьдардаг 3-4 иргэнтэй нийлж хоршоо байгуулжээ.


Аж ахуй маань өргөжүүлэн гахай, тахиа үржүүлдэг болов. Газар, тариалангийн ажил улирлын чанартай тул өвлийн улиралд түр зогсоно. Тэрээр төрөлхийн сонсголын бэрхшээлтэй, сул хараатай тул ажил олгогч нар ажилд авахаас татгалздаг байна. 2003 оны намар авга ах нь түүнийг "Хорол трейд" ХХК-ний нарийн боовны цехэд ажилд оруулсан тэр үеэс эхлэн ирээдүйн бизнесээ эхлэх анхны суурь тавигджээ. 2015 оны 9-р сард тэрээр Багахангай дүүрэгт шилжин ирж "Нүнжиг од" нарийн боовны цехийг үүсгэн байгуулж, өдрөөс өдөрт хүмүүст танигдаж бүтээгдэхүүнийхээ нэр төрөл борлуулалтаа нэмэгдүүлэн ажиллав. 2017 оны 7-р сард "Нүнжиг од" цех "Арвин буудайн хишиг" ХХК болон өргөжсөн. Энэ хугацаанд 2017 оны Багахангай дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс 2 сая төгрөгийн зээл авч шаардлагатай тоног төхөөрөмжөөр үйлдвэрлэлээ өргөжүүлэн талх, нарийн боовныхоо нэр төрлийг нэмэгдүүлж одоогоор дүүргийнхээ болон Төв аймгийн Баян, Баянжаргалан сумын иргэдийн хэрэгцээнд 2 төрлийн талх, 10 нэр төрлийн нарийн боов нийлүүлж байна. Мөн 2 хүнийг ажлын байраар ханган өдрөөс өдөрт борлуулалтаа нэмэгдүүлэн ажиллаж байгаа хөдөлмөрч иргэн юм.



## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ



Нийслэл хотын төвийн дүүргүүдийн нэг болох Чингэлтэй дүүрэг нь 8930 га газар нутагтай. Нутаг дэвсгэрийн 49 хувийг улсын тусгай хэрэгцээт газар, 36,9 хувийг хот, суурин газар, 10,6 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар эзэлдэг. Засаг захиргааны нэгжийн хувьд 19 хорооноос бүрддэг. 2018 оны статистик мэдээнд дурдсанаар 40017 өрх айлийн 157258 хүн ам оршин сууж байна. Тэдний 4727 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд 2418 нь эрэгтэйчүүд, 2309 нь эмэгтэйчүүд байна.



### ТҮВШИНХҮҮГИЙН ТУЛГА: **АЖИЛТАЙ, ТОГТМОЛ ОРЛОГОТОЙ БАЙВАЛ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БИДЭНД СААД БОЛОХГҮЙ**



Түвшинхүү овогтой Тулга 1985 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг, тус дүүргийн 16 дугаар хороонд 1989 оноос одоог хүртэл амьдарч байна.

Т.Тулга нь 1987 онд ахуйн ослын улмаас баруун хөл гарын сарвууны саажилттай болж,






хөдөлмөрийн чадвараа 60 хувь алдсан. Т.Тулга нь 2012 оноос хойш хувиараа аяны майхан, пийшин засварын чиглэлээр өрхийн үйлдвэрлэл эрхэлж байна. Майхан, пийшин засварын үйлчилгээгээ захиалгаар гүйцэтгэдэг бөгөөд, 2015 онд "хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-өөс 5 сая төгрөгийн дэмжлэгийг авч ажлын байраа өргөтгөж, улмаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн хорооныхоо ажилгүй хоёр иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна.



## БАЯНГОЛ ДҮҮРЭГ



2018 оны статистикт дурдсанаар Баянгол дүүрэгт 59,536 өрхийн 226,869 хүн амьдарч байна. Энэ нь Улаанбаатар хотын нийт хүн амын 15 хувийг эзэлж байгаа юм. Тус дүүрэг нь нийслэл хотын төвийн дүүргүүдийн нэг юм. Эрүүл мэндийн төвийн 2018 оны "ХБХ-ний хяналтын тайлан"-аар тус дүүрэгт 4274 хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдарч байгаа юм. Үүнээс 0-16 насны 610 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.



### ЮНДЭНГИЙН БАТ-ЭРДЭНЭ: УРЛАГ, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ НЬ СЭТГЭЛ ЗҮЙН БОЛООД БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛД ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ



Юндэн овогтой Бат-Эрдэнэ 1968 онд төрсөн. 51 настай, хөлний судасны өргөсөл оноштой. Хөдөлмөрийн чадвар алдалт 60 хувьтай. Цахилгаан хангамжийн инженер мэргэжилтэй. АЙФО ОУБ-ын "Удирдлагуудыг чадавхижуулах" 50 сая төгрөгийн төслөөр удирдлагын академид сургагч багшаар суралцаж төгссөн. Англи хэл, компьютерийн анхан шатны мэдлэгтэй.

2004 оноос Төмөр замд зургийн инженер, ХБИ-ийн үндэсний холбоонд аж ахуй, төслийн удирдагчаар тус тус ажиллаж байсан. Одоо “Сити плаза” компанид мэргэжлээрээ буюу аж ахуй, цахилгааны инженерийн чиглэлээр ажиллаж байна. Тэрээр өвчиндөө шантралгүй сурч, хөдөлмөрлөх үйлсээ үргэлжлүүлсээр байдаг чадварлаг нэгэн юм. ХБИ-ний ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд иргэдийн бүлэг үүсгэн 4-5 хүнтэй баг бүрдүүлж БГД-ийн 20-р хороонд гэрэлтүүлгийн ажил, хүүхдийн бялдаржуулах тоглоомын талбай, 2\*2 хэмжээтэй сүүдрэвч хийж, орчны тав тухыг бүрдүүлж, оршин суугчдын талархал хүлээсэн. 2019 онд Баянгол дүүргийн Агро парсад хүнсний ногоо, нарийн ногоо тарихаар хөтөлбөрт хамрагдаад байна. Дүүргээс бага хэмжээний газар, хүлэмжийг түүнд олгохоор зэхсэн. Ю.Бат-Эрдэнэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамт хүнсний ногооны тариалалт хийж, ургацаа хураан хэд хэдэн өрхийн амьжиргааг дээшлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тэрээр дугуйн болон тээквандогийн Олон улсын хэмжээний мастер цолтой. Боксын спортын клуб ажиллуулдаг. Мөн өөрийн сонирхолыг хөгжүүлж, арьсан эдлэлээр бүтээл хийдэг ба үүнийгээ хүүхэд, залуучуудад зааж сургадаг. Энэ чиглэлээр бэлэг дурсгалын болон арьсан урлалын зүйл, цүнх, эсгий углааш, гутал хийж дүүргийн болон нийслэлээс зохион байгуулдаг үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцож байна.


Тэрбээр хөгжлийн бэрхшээлтэй гээд зүгээр сууж, хүнээс тусламж авч амьдрахыг боддоггүй, харин нийгмийн сайн сайхны төлөө хийж бүтээж явах хүсэл, эрмэлзэлтэй иргэн юм. Мөн урлаг, спортоор дамжуулан хүүхэд, залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, муу зуршлаас салгах, тэсвэр тэвчээртэй болгох, хүнтэй зөв харьцах, зөв амьдрах арга ухаанд сургах зорилго тавин ажилласаар байна.



## СҮХБААТАР ДҮҮРЭГ



20,8 мянган км кв газар нутагтай. Нийслэлийн төвийн дүүрэг юм. 20 хорооны 38272 өрхөөс бүрдэнэ. 142.344 мянган хүн амтай. Энэ нь Улаанбаатар хотын нийт хүн амын 9,5 хувийг эзэлж байна. 2018 оны статистик мэдээгээр Сүбаатар дүүрэгт 3103 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 0-16 насны 289 хүүхэд оршин сууж байна.



## ЖАМБАЛЖАМЦЫН УСНАКА: СУВИНЕР БҮХЭН ЦАГ ҮЕИЙН ХӨГЖЛИЙН ТҮҮХ ӨГҮҮЛДЭГ

Жамбалжамцын Уснака 1953 онд Төв аймгийн Баянцогт суманд төрсөн. 1969 онд авто машины осолд орж, баруун хөлний түнхний үеэр тайруулсан бөгөөд эм тарианы хордлогын улмаас сонсголгүй болсон. 1973-1975 онуудад монгол зургийн дугуйланд нэрт зураач Жамсран багшийн удирдлага дор 3 жил суралцаж зураач мэргэжлийг өвлөсөн. 1976-1998 онд Б.Шаравын нэрэмжит хэвлэл чимэглэлийн үйлдвэрт хэвлэлийн эх бэлтгэгч, зураач, модон урлалын тасагт хүүхэлдэй чимэглэгч зураачаар тасралтгүй 22 жил ажиллаж, ажил хөдөлмөрийн зам мөрөө тасралтгүй үргэлжлүүлсэн нэгэн юм.





1993 оноос өнөөг хүртэл Монголын тулах хөдлөх эрхтэн дутуу, гэмтэлтэй иргэдийн нийгэмлэгт ажиллаж байна. Ж.Уснака нь давхар соготой хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн боловч сувинерийн модон хүүхэлдэйн шинэ загваруудыг төрөл бүрийн хэмжээтэй хийж бэлтгэдэг.

Ж.Уснака нь 1976 оноос ажиллаж эхлээд 2013 онд “Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одон”-оор шагнагдах хүртэл 37 жилийн хугацаанд төрөл бүрийн сэдвээр мэндчилгээ, ил захидлын 13 ширхэг эх загвар, 5 байгууллагын байнгын болон тэмдэглэлт ойн лого, энгэрийн тэмдэгийн эх загвар, монгол үндэсний ёс заншил уламжлалыг харуулсан мод, торго, арьсаар урласан 54 нэр төрлийн сувинерийн хүүхэлдэйн эх загварыг туурвижээ. 1992 онд Монгол улсаа төлөөлөн бүх Оросын сонсголгүй иргэдийн 2-р фестивальд “Бөмбөгтэй сарлаг” зурган эх загвар нь тусгай байрын шагнал хүртсэн. 1995 онд Монголын тулах хөдлөх эрхтэн дутуу гэмтэлтэй иргэдийн нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр Польш улсад болсон ОУ-ын тахир дутуу иргэдийн фестивальд 20 нэр төрлийн сувинерийн эх загвар бүтээлээр оролцож тусгай байрын шагнал хүртэж байсан. Түүний шилдэг бүтээлүүдийг дурдвал: “Бөртэ Тэмүүжин”, “Чингэсийн морьт баатар”, “Баатар хос”, “Эртний шатар”, “Дөрвөн уулын савдаг”, “Ерөөл” зэрэг бүтээлүүд юм. Ж.Уснака бүтээл туурвихын хажуугаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад сургалт зохион байгуулж, 70 гаруй шавьтай болжээ.

Ж.Уснакагийн цуцалтгүй хөдөлмөрч, шинийг санаачлагч зан чанар нь Монгол үндэсний ёс заншил, уламжлалыг таниулан сурталчилж, хойч үедээ өвлүүлэхэд оруулж байгаа үнэтэй хувь нэмэр болж, хөгжлийн бэрхшээлтэй хүн хэрхэн сурч, ажиллахын үлгэр дууриал болж байна.



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ



Баян-Өлгий аймаг нь Монгол Улсын хамгийн баруун хязгаарт далайн түвшнээс дээш 1301-4374 метрт оршино. Аймгийн төв нь Өлгий хот. Баян-Өлгий аймагт манай орны хамгийн өндөр цэг болох Алтай Таван Богд уулын Хүйтэн оргил (4374 м) байдаг ба нутаг дэвсгэрийн хувьд Монгол орны уулархаг бүс нутгийг хамран оршдог. Нийт 93,000 хүн амтай, үүний 70 орчим хувийг казак үндэстэн, үлдсэн хувь нь дөрвөд, урианхай, тува, халх ястнуудаас бүрдэнэ. Засаг захиргааны 14 нэгжтэй, 13 сум, 1 тосгоноос бүрдэнэ. Нийслэл Улаанбаатар хотоос 1760 км зайд оршдог. Нийт хүн амын 4,9 хувь буюу 4608 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

### ДАУИТХАНЫ ХАБЫЛХАТ: "БИ АМЬДРАЛД ХАЙРТАЙ"

Дауитхан овогтой Хабылхат нь 27 настай. Ам бүл 8, аав ээж ах дүү нарын хамт амьдардаг. Одоо Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 9 дүгээр багт оршин суудаг. 2012 онд Налайхын уурхайд ажиллаж байхдаа нурангинд дарагдаж, хүнд гэмтэл авсны улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан. Д.Хабылхат урлагийн авьяастай, чадварлаг залуу юм. Тэрбээр өөрийн авьяас чадварыг хөгжүүлэн нийгмийн амьдралд бусадтай адил тэгш оролцож яваа идэвхтэй хөдөлмөрч иргэн юм. Хабылхат хүн бүхэнд өөртөө итгэх итгэлийг бий болгох, амьдралын сайхныг бусадтай хуваалцах зорилгоор "Амьдралаа хайрлая" бие даасан тоглолтоо зохион байгуулсан. Тэрээр тогтмол орлоготой байж, амьдралын чанараа сайжруулахын тулд хувиараа такси үйлчилгээ эрхлэн хөдөлмөрийн чадвараа алдсан олон хүнд үлгэр жишээ болж яваа хөдөлмөрч нэгэн юм.



## БУЛГАН АЙМАГ




Монгол орны хойд хэсгийн хангайн уулархаг бүсэд оршдог. Ойт хээр болон тал хээр хосолсон 48,7 мянган км кв нутаг дэвсгэртэй. Засаг захиргааны 17 нэгжтэй. 16 сум 1 тосгоноос бүрдэнэ. Нийслэл Улаанбаатар хотоос 330 км зайтай оршдог. 2018 оны статистик мэдээгээр 61366 мянган хүн ам суурьшиж байна. Үүнээс 2056 иргэн нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Энэ нь нийт хүн амын 3,3 хувийг эзэлж байна. Тэдний 1199 нь эрэгтэйчүүд байгаа бол 857 нь эмэгтэйчүүд байгаа юм.

### ПОЛООЗЫН САРАН: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ТОГТМОЛ ОРЛОГО ХАМГИЙН ЧУХАЛ

Полооз овогтой Саран анх 2000 онд Булган аймагт ирж, хадам аавынхаа бизнест тусалж ажлын гаргаагаа эхэлсэн. Цаашид бие даан хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэхээр оёдлын ажил хийж эхэлсэн. Тэрээр өөрөөсөө гадна хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг ажлын байраар ханган ор хөнжлийн даавуу, өлгийний иж бүрдэл зэргийг оёж борлуулж эхэлснээр Булган аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэн ХБИ-ийн холбоо болтлоо өргөжих эх суурийг тавьсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрх тогтмол орлоготой байж, орлогоо нэмэгдүүлэх нь чухал гэдгийг өөрийн амьдралаар ухаарсан Саран гуай зөвхөн өөрийнхөө төлөө бус Булган аймагт оршин суугаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрийн төлөө ажилладаг тууштай хөдөлмөрч эмэгтэй юм.

Тэрээр 2004 онд компьютер, канон, телефон утасны үйлчилгээг явуулж эхлэхэд хөгжлийн бэрхшээлтэй 2 хүнийг сургаж ажиллуулсан. Мөн уран хатгамалын болон хараагүйчүүдийн холбооноос зохион байгуулсан сургалтуудад аймгийнхаа ХБИ-ийг өргөн хамруулж амьдралаа дээшлүүлэхэд нь үргэлж дэмжлэг үзүүлж байна. ХБИ-ийг ажлын байраар хангахад анхаараад зогсохгүй тэднийг нийгмийн оролцоотой, хамт олон дунд хөгжих боломжийг бүрдүүлэхийн тулд “Мөрөөдөл”, “Тэгш дүүрэн” гэсэн 2 бүлгийг ажиллуулж эхэлсэн.




## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТЭРГҮҮН ТУРШЛАГУУД



“Мөрөөдөл” бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хийсэн бүтээлийг борлуулах, цэцэг үрслүүлж зарах гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бол харин “Тэгш дүүрэн” оёдлын цех нь оёдол эсгүүрийн чиглэлээр ажиллаж байна. Ингээд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг болж, 2014 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдан 2 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн. Улмаар ширхгийн хоол, хөөсөн чихэр хийх тоног төхөөрөмж авч дахин хоёр ажлын байрыг бий болгосон юм.

2017 оноос хөгжлийн бэрхшээлтэй ахмад настанд ортопедийн туслах хэрэгслийг халамжийн хөнгөлөлтөөр нийлүүлэх тендерт шалгарч хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран гэрээ байгуулж Булган болон Орхон аймгийн иргэдэд үйлчилж байна. Иргэдэд найдвартай бараа бүтээгдэхүүн нийлүүлж ажилласны үр дүнд 2018 онд ахин гэрээгээ сунган ажиллаж байна. Ажлын байрандаа ХБИ-г төлөвшихөд нь тусалж дэмжих бүхий л төрлийн зөвлөгөөг өгч, хагалгааны болон туслах хэрэгслийн зардлын хөнгөлөлтөд хамруулах, бичиг баримтын зөрчлийг арилгуулах гээд иргэд рүү чиглэсэн олон ажлыг зохион байгуулж байна. Цаашид Булган аймгийн хэмжээнд хөтөч болон дохионы хэлний орчуулагч бэлтгэх, оюуны хөнгөн хэлбэрийн хомсдолтой хүмүүс болон саажилттай хүмүүсийг өөртөө үйлчлэх төвтэй болгож нийгэмшүүлэх, сумдын салбар зөвлөлүүдийг чадавхжуулж үйл ажиллагааг нь ахиулах зорилго тавин ажиллаж байна.





## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ



Говь-Алтай аймаг 141447 км.кв нутаг дэвсгэртэй, Алтайн уулархаг бүс, говь хээрийн бүсийг хамран оршдог. Аймагийн төв нь Алтай хот. Хүн амын дийлэнх хувийг халх үндэстэн юм. Монгол орны уулархаг, говь хээрийн бүсэд оршдог. Засаг захиргааны нэгжийн хувьд 18 сум, 83 багтай. 2018 оны жилийн эцсийн байдлаар Говь-Алтай аймаг 58320 хүн амтай, 16711 өрхтэй байна. Нийт хүн амын 4,8 хувь нь буюу 2789 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Тэдний 1604 эрэгтэйчүүд, 1185 нь эмэгтэйчүүд юм.

### ДУЛАМЫН ТҮМЭНДЭЛГЭР: ҮНДЭСНИЙ ХУВЦАСНЫ УРАН ХИЙЦИЙГ ДОЛООН ШАВЬДАА ӨВЛҮҮЛСЭН



Дулам овогтой Түмэндэлгэр нь 1972 онд Говь-Алтай аймгийн Халиун сумын нутагт төрсөн. Ам бүл 2. Хүүгийн хамт амьдардаг, өрх толгойлсон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй. 1980-1988 онд Халиун сумын дунд сургуульд сурч 8-р анги төгссөн. Өвчний улмаас цаашид суралцаж чадаагүй бөгөөд 18 настайгаасаа эхлэн Монгол үндэсний дээл, хувцас оёж эхэлсэн байна. Д.Түмэндэлгэр нь өөрийн мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхийн тулд 2010 онд зүүмэл даавуун урлалын чиглэлээр, 2014 онд Европ хувцасны технологи эсгүүрийн чиглэлээр сургалтад хамрагдаж амжилттай төгссөн. Энэ хугацаанд өөрийн мэдсэн сурсан зүйлээ бусдад заан сургаж, 7 шавь төрүүлсэн байна. Тэрээр өвчинд шаналж суухын оронд өөртөө төдийгүй өрөөл бусдад тусалж, өрхийн амьжиргаагаа нэмэгдүүлэн үндэсний дээл хувцасны уран нарийн хийц, ур ухааныг хойч үедээ өвлүүлэн үлдээж, оюуны болоод биеийн хөдөлмөрийг эрхэлж яваа бахархал болсон иргэн юм.

## ДАРХАН УУЛ АЙМАГ



Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд хэсэгт Хэнтий нурууны салбар уулсын дунд Хараа голын зүүн хойд хөндийг хамарсан 327,5 мянган га тэгш өндөрлөг газар нутагтай. Монгол орны тал хээрийн бүсэд оршдог. Засаг захиргааны 4 нэгжтэй буюу 4 сумдад хуваагддаг. ҮСХ-ны 2018 оны эцсийн байдлаар нийт 104238 хүн амтай. Тэдний 4262 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд энэ нь нийт хүн амын 4,1 хувийг эзэлж байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2398 нь эрэгтэйчүүд, 1864 нь эмэгтэйчүүд юм.

### ЛУВСАНГИЙН ОТГОНДУЛАМ: ГАЗРЫН ШИМ, ХӨДӨЛМӨРИЙН ҮР ХОЁР ХҮНИЙ АМЬДРАЛЫГ ТЭТГЭДЭГ

Л.Отгондулам нь 1964 онд Дархан хотод төрсөн, нөхөр 4 хүүгийн хамт амьдардаг. Төрөлхийн нуруу нугасны гэмтэлтэй. 1972-1981 онд ЕБ-ын 4-р дунд сургууль төгссөн. Анх хашаандаа хүнсний ногоо тариалж, өөрийн ам бүлээ эрүүл хүнсээр ханган амьжиргаандаа нэмэр болж байсан түүний хөдөлмөрийн үр шим арвижиж, хүнсний ногоо ханган нийлүүлэгч болтлоо өсөн дэвжсэн юм. 1999 оноос тарьсан ногоогоо худалдаалахаар шийдэж, аймгийнхаа худалдааны төвд лангуу түрээсэлснээр өрхийн орлоготой болж эхэлсэн юм. Цуцашгүй хөдөлмөрийнхөө үр шимээр урамшсан тэрээр 2000 онд хашаандаа 40 тн багтаамжтай зоорь барьж, хүнсний ногоогоо хадгалан борлуулснаар тогтмол орлоготой болсон байна. Түүгээр ч зогсохгүй Сэлэнгэ аймгийн Хушаат суманд 2 га талбайд хүнсний ногоо тариалдаг болжээ. Тэрээр “Бат гурван тулга” нөхөрлөлөө 2003 онд байгуулсан бөгөөд 10 хүнийг тогтмол ажлын байраар ханган ажиллаж байна. Мөн үйл ажиллагаагаа өргөтгөж байгалийн жимс, жимсгэнээр чанамал хийж ашиг орлогоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрийнхөө сайн туршлагыг хуваалцаж ногоо тарих, нөөшлөх сургалт явуулж, зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Л.Отгондулам нь ажил хөдөлмөрийн арвин туршлагатай, түүнийгээ бусадтай харамгүй хуваалцан өөрийн нэгэн адил олон хүний амьжиргааг дээшлүүлэн нийгмийн амьдралд өөрийн оролцоо, хувь нэмрийг оруулсаар байгаа дайчин эмэгтэй юм.



## ДУНДГОВЬ АЙМАГ




Дундговь аймаг 1941 онд байгуулагдсан. Аймгийн төв Мандалговь, нийслэл Улаанбаатараас 280 км зайд оршдог. Нутаг дэвсгэрийн хувьд Монгол орны тал хээр, говь хосолсон бүсэд багтдаг. Дундговь аймаг засаг захиргааны нэгжийн хувьд 15 сум, 66 багт хуваагддаг. 2017 оны эцсийн байдлаар Дундговь аймагт 14556 өрхийн 46.4 мянган хүн амтай. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт 1830 хүн оршин суудаг. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 43 %-ийг эмэгтэйчүүд, 57 %-ийг эрэгтэйчүүд эзэлж байна.

### НЯМСҮРЭНГИЙН ДАШ: БИЧГИЙН СОЁЛ БОЛ ҮНДЭСТНИЙ ТҮҮХ

Н.Даш нь 1988 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төржээ. Тэрээр 1996-2006 онд төрөлх сумандаа ЕБ-ын 3-р бүрэн дунд сургуулийг дүүргэж, 2006-2010 онд МУИС-ийг “Эх бичиг судлаач” мэргэжлээр төгссөн. 2011 оноос одоог хүртэл “Монсудар” хэвлэлийн газарт Монгол хэл, бичгийн редактор, тользүйчээр ажиллаж байна. Н.Даш нь 1994 онд 6 настай байхдаа өндрөөс унаж, улмаар сонсгол мууджээ. Тэрээр 2008 онд группэд



хамрагдаж, эмчийн хяналтанд орсон байна. Өөрийн авьяас, хүсэл сонирхолдоо хөтлөгдсөн тэрээр албан ажлаа хийхээс гадна 2013 оноос монгол бичиг, бийрийн бичлэгийн сургалтыг явуулж эхэлжээ. Мөн монгол бичгийн уран бичлэгээр төрөл бүрийн бэлэг дурсгалын захиалгат үйлчилгээ явуулж байна.





Монгол бичгийн холбогдолтой эрхлэн гаргасан бүтээлүүд:

- |  |               |
|--|---------------|
| 1. "Монгол бичгийн зөв бичихзүйн толь"             | 2012, 2018 он |
| 2. "Монгол бичгийн дүрс ялган бичих үгийн толь"    | 2013 он       |
| 3. "Монгол бичгийн уламжлалт бичлэгтэй үгийн толь" | 2013 он       |
| 4. "Монгол бичгийн бичлэг ижил үгийн толь"         | 2013 он       |
| 5. "Монгол хэлний тайлбар толь"                    | 2014, 2018 он |
| 6. "Монгол хэлний иж үгийн толь"                   | 2015, 2019 он |

Тэрээр Монголын бичгийн их өв соёл болох уран бичлэгийг өөрийн гарын уран хөдөлгөөн, оюун санааны давтагдашгүй хийцээ шингээн бүтээсээр яваа чадварлаг, хөдөлмөрч иргэдийн нэгэн төлөөлөл юм.



## ОРХОН АЙМАГ



1976 онд Эрдэнэт хот нэртэй байгуулагдсан. 1994 оноос Орхон аймаг болж, Засаг захиргааны 2 нэгжтэй болсон. 844 км кв нутаг дэвсгэртэй. Монгол орны тал хээрийн бүсийг хамарсан тэгш өндөрлөг газар нутагтай. 101.789 мянган хүн амтай. 2018 оны жилийн эцсийн статистик мэдээгээр Орхон аймагт 4315 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Тэдний 2352 нь эрэгтэйчүүд, 1963 нь эмэгтэйчүүд байна.

### БЯМБАЖАВЫН ЗАМБАГАЦЭЦЭГ: ХӨДӨЛМӨРЧ ГАР МИНЬ МИНИЙ АМЬДРАЛЫГ “ХӨЛ ДЭЭР НЬ” БОСГОСОН

Бямбажавын Замбагацэцэг 1967 онд Улаанбаатар хотод төрсөн. Төрөлхийн тулгуур эрхтний бэрхшээлтэй. 1985 онд Улсын тэргүүний 28-р сургуулийг төгссөн. 1991 оноос Монгол болон Буриад гутал хийж сурсан. 1993 онд Эрдэнэт хотод шилжин ирж, өрхийн үйлдвэрлэл эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлж эхэлсэн. 2008 онд хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас зохион байгуулсан шүрэн урлалын сургалтад, 2011 онд гутал засварын сургалтад тус тус сууж, мэдлэг ур чадвараа дээшлүүлэн улмаар өрхийн үйлдвэрлэл эрхэлж эхэлсэн. 2014 онд аймгийнхаа хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээс 2 сая төгрөгийн буцалтгүй тусламж авч, ажлын байраа өргөтгөн хатуу оёдлын машин, бусад тоног төхөөрөмжийг авчээ. Бүтээгдэхүүнээ төрөлжүүлж, савхин гутал хийж эхэлсэн. Хийсэн зүйлдээ сэтгэл ханаж, хойшоо суулгүй эсгий урлал, туузан урлал, үндэсний дээл хувцас ч хийдэг болсон юм. 2018 онд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдан 2 хүнийг ажлын байраар хангаж, 1.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж авсан. Ингэснээр хэрээсний машин, шулуун оёдлын машин, уурын индүү зэргээр үйлдвэрээ баяжуулан “Шод шаглаа” оёдол засвар газрыг ажиллуулах болсон. Оёдол засварын үйлчилгээ эрхлэхийн хажуугаар хүнсний ногоо тариалж, өрхийн амьжиргаандаа нэмэрлэж, зорилтот бүлгийн айл өрхийг үнэ төлбөргүй хүнсний ногоогоор хангаж, “Хариу нэхээгүй тус” аяныг 3 жил дараалан зохион байгуулжээ. Б.Замбагацэцэг нь 1991-2019 он хүртэл 18 жилийн ажлын туршлага хуримтлуулсан залуу үедээ хөдөлмөр, зүтгэлийн бахархалт дууриал болсон иргэн юм.



## ӨВӨРХАНГАЙ АЙМАГ



Өвөрхангай аймаг Хангайн нурууны салбар уулс, Алтай нурууны салбар уулсын бүсийг хамран оршдог, элсэрхэг тал хээр нутагтай. Газар нутгийн хэмжээ 63,5 мянган км кв, засаг захиргааны 19 сумтай. Төв нь Арвайхээр хот. Нийслэл Улаанбаатараас 430 км зайтай. ҮСХ-ны 2018 оны жилийн эцсийн байдлаар 116.6 мянган хүн амтай, нийт хүн амын 4103 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Тэдний 42.6 хувь нь эмэгтэй, 57.4 хувь нь эрэгтэй байна.

### Б.ӨЛЗИЙБАЯР: АЙМАГТАА ШИЛДЭГ АВТЫН ЗАСВАРЧИН

Иргэн Б.Өлзийбаяр нь 1972 оны 12 сарын 11-нд Өвөрхангай аймгийн Сант суманд төрсөн. Ам бүл 3. Ээж болон дүүгийн хамт амьдардаг. Дүү нь мөн хөгжлийн бэрхшээлтэй. Б.Өлзийбаяр нь төрөлхийн хайрстах эмгэг оноштой, хөдөлмөрийн чадвараа 80 хувь алдсан. Тэрээр 16 нас хүртлээ аав, ээжийн асрамжинд амьдарч байгаад 18 наснаас өөрийн сонирхол, авьяасын дагуу өөрийгөө дайчлан цахилгаан засвар, авто машин засвар, сийлбэр, авдар сав, гэрийн мод эрээлэх зэргээр ажил хөдөлмөр хийж сурчээ. Түүний хийсэн гэрийн мод, цахилгааны болон машины засвар маш сайн гүйцэтгэлтэй байдаг тул сумандаа төдийгүй, хөрш зэргэлдээ сумдын иргэд зорин ирж үйлчлүүлдэг.



Анх 1990 оноос эхлэн сийлбэртэй таваг, гэрийн модон эдлэл хийж эхэлснээр ажил хөдөлмөрийн гараагаа тэрээр одоо ч амжилттай үргэлжлүүлж явна. 2003 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2 сая төгрөгний зээл олгож, түүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн юм. Тэрээр 2008 онд аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үзэсгэлэн худалдаа"-нд оролцон 2-р байранд орж, цахилгаан хөрөө, харуул, дерил зэрэг хөдөлмөрийн



багажаар шагнуулсан нь мөн л түүний хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг болжээ. 2018 онд дахин "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гаас 3 сая төгрөгийн зээл авч амжилттай ажиллаж байгаа тэрээр хөдөлмөр бүтээл, сэтгэлийн хаттай явахын бодит жишээ болсон бахархал, дуурайлтай иргэдийн маань нэг болжээ.

## ӨМНӨГОВЬ АЙМАГ



Өмнөговь аймаг нь 165,0 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, аймгийн төв нь Даланзадгад хот. Засаг захиргааны нэгжийн хувьд 15 сум, 59 багтай. Монгол орны говь хээрийн бүс нутагт оршдог. Нийслэл Улаанбаатар хотоос 553 км зайтай. 2018 оны жилийн эцсийн статистик мэдээгээр 68114 хүн ам, 21983 өрх тус аймагт оршин сууж байна. Тус аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 1985 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 1086 нь эрэгтэй, 899 эмэгтэй. Энэ нь аймгийн нийт хүн амын 2.4 хувийг эзэлж байна.

### ТУЛГАХҮҮГИЙН БАРХАС: БИЧИГ ҮСЭГ БҮРЭН СУРАХ НЬ ХАРИЛЦААНД ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ

Тулгахүү овогтой Бархас нь 1984 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутагт айлын ууган хүү болж мэндэлжээ. Төрөлхийн хэл ярианы болон сонсголын бэрхшээлтэй. 22 нас хүртлээ аав ээжийн асрамжинд мал маллах арга барилд суралцан хүмүүжсэн. Ам бүл 2, эхнэрийн хамт амьдардаг. Эхнэр Б.Ганчимэг хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвараа 100 хувиар алдсан хэл яриа, сонсголын бэрхшээлтэй. Т.Бархас нь бие даан бичиг үсгийн боловсрол эзэмшиж, өөрийгөө бусдад ойлгуулж, илэрхийлэх болсон нь түүний хувьд нийгмийн амьдралд оролцоотой байх маш том амжилт болсон юм.



Өөрийн бодсон хэлэх зүйлээ бусдад сайн ойлгуулж чаддаг, бусадтайгаа ойлголцон ажиллаж чаддаг Т.Бархасын хувьд 2015 оноос эхлэн хамт олны дунд ажиллаж байна. Тэрээр тус аймгийн Арвин туулай ХХК-нд ажиллаж, өрхийн амьжиргаагаа дээшлүүлэн бэрхшээлгүй иргэдийн нэгэн адил амьдарч байгаа хөдөлмөрч залуу юм. Тус байгууллагын нүүр царай болох үйлчилгээний засал чимэглэл, засвар, мужааны ажлыг үйлчлүүлэгчдийн сэтгэлд нийцсэн байдлаар тохижуулахад гар бие оролцон амжилттай ажилласан байна. 2018 онд камерын өрөө, нягтлан бодогчийн өрөө, сахиулын байр, гоо сайхны өрөө, гал зуухны байруудыг шинээр барьж гүйцэтгэх, их засвар хийх зэрэг ажлуудыг чанартай хийж гүйцэтгэсэн. Ажиллахын зэрэгцээ жолооны курст суралцаж, такси үйлчилгээ эрхэлж байна. Мөн чөлөөт цагаараа дугуй спортоор хичээллэхээс гадна Өмнөговь аймаг дахь ХБИ-ийн салбар зөвлөлөөс зохион байгуулж буй олон талт арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцон хувь хүний хөгжил, манлайлын тод жишээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж яваа иргэн юм.

## ТӨВ АЙМАГ



Төв аймаг Монгол улсын дорнод төв хэсэгт 74,042.37 км газар нутгийг эзлэн оршдог. Төв аймгийн төв нь Зуумод хот боловч газар нутгийн төв хэсэгт нь нийслэл Улаанбаатар хот оршдог онцлогтой. Аймгийн хүн амын тоо 2018 оны статистик мэдээнд дурдсанаар 95662, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүн 3211 байгаа нь нийт хүн амын 3,4%-ийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 1936 буюу 58,8% нь эрэгтэйчүүд, 1275 буюу 31,2% нь эмэгтэйчүүд юм.

### ЧОЙЖИЛЗАВЫН ПҮРЭВБАЗАР: ИРГЭДИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ НЬ ТЭДЭНД ҮЗҮҮЛЖ БАЙГАА ХАМГИЙН ТОМ ТУС

Ч.Пүрэвбазар нь 1966 онд төв аймгийн Баяндэлгэр суманд төрсөн. 1974 онд тус сумын дунд сургуульд орж суралцаад 1982 онд 8-р ангийг төгсөж, 1982 оны 9 сард Төв аймгийн Угтаалцайдам сумын ТМС-д трактор комбайнчны мэргэжлээр 2 жил суралцаж төгссөн. 2013-2015 онд Налайхын МСҮТ-д суралцаж цахилгаанчин мэргэжлийг эзэмшсэн. Ч.Пүрэвбазар нь гэмтлийн улмаас тулгуур эрхтний бэрхшээлтэй болоод өдгөө 10 гаруй жил болжээ. 1984 оноос эхлэн Баяндэлгэр сумын Хэрлэн баян нэгдэлд тракторын жолоочоор, 1989 оноос тус сумын Нийтийн ахуй үйлчилгээнд нормчин, жолоочоор, 2008-2010 онд цахилгаанчнаар ажиллаж байгаад эрүүл мэндийн шалтгаанаар 2011 онд группт орсон. Одоо сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүнээр ажиллаж байна.



Тэрээр 1995 оноос эхлэн хувиараа эсгий, эсгий гутлын өрхийн үйлдвэрлэлийг эрхлэн жилд 3-4 ажлын байрыг бий болгож 500-1000 хос эсгий гутал, 50-100 ш эсгий бүрээс, дэвсгэр үйлдвэрлэдэг. Тус үйлдвэр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, малчдыг дулаан гутал, гэрийн эсгийгээр хангахыг эрхэм зорилго болгон ажиллаж байна. Үйлдвэрлэлээ өргөжүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байр бий болгон хөдөлмөрийн зах зээлийг тэлсээр байгаа нь иргэн Ч.Пүрэвбазарын бусдад бахархал дуурайл болсон амжилт билээ.



## ХОВД АЙМАГ



Ховд аймаг нь Монгол улсын баруун хойд, Алтайн уулархаг бүсэд оршдог. 84486 км кв газар нутагтай. Төв нь Ховд хот. Засаг захиргааны 16 нэгжтэй. Нийслэл Улаанбаатараас 1580 км зайд оршино. Халх, ойрад, урианхай, баяд зэрэг олон үндэстэн ястны нутаг юм. 2018 оны статистик мэдээгээр тус аймаг нь 88,4 мянган хүн амтай байна. Тэдний 2639 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд энэ нь нийт хүн амын 3.1 хувийг эзэлдэг. Нийт ХБИ-ийн 1544 нь эрэгтэй, 1095 нь эмэгтэй байна.

### ПҮРЭВИЙН ИДЭР: ХӨДӨЛМӨРЧ, СЭТГЭЛИЙН ТЭНХЭЭТАЙ БАЙХАД АМЬДРАЛ БҮТЭН БОЛДОГ

Пүрэвийн Идэр нь Ховд аймгийн Чандмань суманд 1975 онд төрсөн. Ам бүл 5, эхнэр 3 хүүхдийн хамт Ховд аймгийн Жаргалант суманд амьдардаг. Төрөлхийн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй. 1983-1991 онд Чандмань сумын 10 жилийн бүрэн дунд сургуульд суралцаж, суурь боловсрол эзэмшсэн. Хүүхэд ахуй наснаасаа эхлэн бие дааж модоор янз бүрийн эд зүйл хийж сурах сонирхолдоо хөтлөгдөн гар урлалын эд зүйл хийж эхэлсэн. 1992-2008 онд аав ээжийн хамт мал маллан амьдарч байгаад 2010 онд эхнэр Ганчимэгтэйгээ гэрлэсэн. Эхнэр нь мөн төрөлхийн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй. Тэрээр 2009 онд ХХҮХ-ээс зохион байгуулсан гар утасны засварчин, 2010 онд мужааны сургалтад тус тус суралцаж хос мэргэжил эзэмшсэн. 2011 онд Мерси-кор олон улсын байгууллагаас 1 сая төгрөгийн санхүүжилт, 2012 онд ХХҮХ-ийн тусгай хөтөлбөрөөс 1 сая төгрөгийн санхүүжилт, 2018 онд ХХҮГ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 1,5 сая төгрөгийн зээл авч ажлын байр, мужааны багаж, тоног төхөөрөмж, түүхийн эд авах эргэлтийн хөрөнгөтэй болж үйл ажиллагаагаа тогтвортой эрхэлж байна.



Одоогоор гэрийн хаалга тооно, гэрийн тавилга /ор, хоолны шкаф, телевизийн суурь, хувцасны шкаф, ширээ сандал, ууц, хэвийн боорцогны модон цар таваг, төрөл бүрийн хэв/ цонхны хүрээ гэх мэт зүйлийг захиалгаар хийж үйлчлүүлэгчдэдээ хүргэн ажиллаж байгаа, Ховд аймгийн үлгэр жишээ хөдөлмөрч иргэн юм.



## ХЭНТИЙ АЙМАГ



Хэнтий аймаг нь 2018 оны статик мэдээгээр 77664 хүн амтай, 25172 өрхтэй. Хүн амын 87,3% нь халх, 8,3% нь буриад, үлдсэн 4,4 хувийг бусад ястан үндэстэн эзэлж байна. Ойт хээр болон тал хээр хосолсон 80,3 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Улаанбаатар хотоос 330 км зайд оршдог. Нийт хүн амын 4.12 хувь нь буюу 3200 хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус аймагт амьдарч байна. Үүнээс 1183 нь эмэгтэй 2017 нь эрэгтэй хүмүүс байна.

### ЧАДРААБАЛЫН БАТБИЛЭГ: МАЛЧ МОНГОЛ УХААН НАМАЙГ НАСААР МИНЬ ТЭТГЭЖ ЯВНА

Чадраабал овогтой Батбилэг 1974 онд төрсөн. Төрөлхийн хэл яриа, сонсголын бэрхшээлтэй буюу 100 хувь хөдөлмөрийн чадвараа алдсан хэдий ч балчир бага наснаасаа аав ээжийнхээ хамт мал аж ахуй, малын удмын сан, монгол зан үйл буюу сур суран эдлэл хийх арга зүйд суралцжээ. Өсөхөөс суралцсан малч хөдөлмөрч монгол ухаанаа өвлөн үргэлжлүүлж, Хэнтий аймгийн Дархан суманд гэр бүлийн хамт мал маллан амьдарч байна. Тэрээр “Баялаг бүтээгчдийн холбоо”, Монголын морин спорт уяачдын холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимд гишүүнээр элсэн сургалт, арга хэмжээнүүдэд амжилттай оролцож байна. Нийслэл, аймаг, сум орон нутагт зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаа, яармагт сур, суран эдлэлээрээ оролцож, улсын баяр наадамд түүний уяж сойсон морьд нь айраг түрүү авсаар байгаа билээ. Монгол ахуй, малч ухааныг үр хойч үедээ өвлүүлж яваа тэрээр Хэнтий аймгийн бахархал дуурайлтай иргэдийн нэг юм.



## ДОРНОГОВЬ АЙМАГ



1931 онд байгуулагдсан. 14 сум, 64 багтай. Аймгийн төв Сайншанд нь улсын нийслэл Улаанбаатар хотоос 450км-т оршдог. Дорноговь аймаг Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог. БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг. Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 61 хувь нь оршин сууж байна. 2018 оны статистик мэдээгээр 69304 хүн амтай. Тэдний дунд 2598 хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдран суудаг. Энэ нь нийт хүн амын 3,7 % бөгөөд тэдний 1595 эрэгтэй, 1003 эмэгтэй байна.

### ДОРЖГОТОВЫН ТҮВШИНДЭЛГЭР: МИНИЙ АЖИЛ ХАМГИЙН СОНИРХОЛТОЙ БАС ХЭЗЭЭД ОРХИГДОХГҮЙ МЭРГЭЖИЛ

1966 онд Дорноговь аймгийн Сайншанд суманд Доржготовын ууган хүү болон мэндэлсэн. Ой өнгөрөөд саа өвчний улмаас нуруу нугас мэдээгүй болж, эцэг эхийн асрамжинд өсчээ. 1982 онд группэд орсон. Өдгөө ам бүл 4. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдарч байна.

Бие даан амьдрах чадвартай болохын тулд инженер мэргэжилтэй ахыгаа дагалдан, дагалдан цахилгаанчин электроник мэргэжлээр засвар үйлчилгээний ажилд дадлагажин улмаар суралцаж цахилгаан, электроникийн засварчин мэргэжлийг эзэмшсэн. Одоо тэрээр орон нутагтаа телевизор засварын үйлчилгээ эрхлэн өрхийн амьжиргаа дээшлүүлэн гэр бүлдээ хариуцлагатай өрхийн тэргүүн юм.



Тэрээр ажиллахын хажуугаар өөрийгөө хөгжүүлэн шагайн харвааны спортоор хичээллэдэг бөгөөд 2009 онд Шагайн харвааны спортын төрлөөр Монгол улсын гарамгай мэргэн цол хүртсэн. 2014 онд Монгол улсын биеийн тамир спортын газрын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан Дорноговь аймгийн амжилттай яваа бахархмаар иргэдийн маань нэг билээ.

## СҮХБААТАР АЙМАГ



Сүхбаатар аймаг Монгол орны говь тал хээрийн өндөрлөг бүсэд 82287 км кв нутаг дэвсгэрийг хамран оршино. Төв нь Баруун-Урт хот. Нийслэл Улаанбаатараас 560 км зайтай. Засаг захиргааны 13 сумтай. 2018 оны статистик баримтаар 62322 мянган хүн амтай байна. Нийт хүн амын 4,1 хувь нь буюу 2603 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж амьдардаг. Тэдний 1492 нь эрэгтэй, 1111 нь эмэгтэй байна.

### АЮУРЗАНЫН БАТБАЯР: ХҮМҮҮСТ АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХИЙГ ХИЧЭЭЖ БАЙНА

1979 онд Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотод мэндэлжээ. 1997 онд ЕБ-ын 2-р сургуулийг төгссөн. Тэрээр 1995 онд тогонд цохиулснаас болж тархины гэмтэл аван, уналт таталт буюу эпилепситэй болж, хөдөлмөрийн чадвар алдалт 70 хувиар тогтоогджээ.

Одоо тэрээр Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 2-р багт арьс, ширэн эдлэлийн чиглэлийн үйлдвэрлэл эрхэлж байна. Анх 2012 оноос эхлэн гэр бүлийн хүнтэйгээ хамтран "Баян шарга" хоршоогоо 2 хүний



бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, анхны бүтээгдэхүүн болох түлхүүрийн оосор, үзэгний сав зэргийг гар аргаар үйлдвэрлэн үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 3 сая төгрөгийн зээл авч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа өргөжүүлэн "Чулуун дарь овоо" ХХК болсон.



А.Батбаяр нь өдөрт 30-35 нэр төрлийн арьс, ширэн гоёлын тэлээ, бүс, цүнх түрийвч, утасны гэр, бүх төрлийн бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэж, өөрсдийн гэрээт дэлгүүрүүд болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас хэрэгжүүлдэг "Сүхбаатарт үйлдвэрлэв" борлуулалтын цэгээр бараа бүтээгдэхүүнээ борлуулж байна. Мөн тэрээр Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 5 оюутныг арьсан эдлэлийн чиглэлээр сурган, дадлагажуулж гэрээгээр ажлын байраар хангасан байна.

## БАЯНХОНГОР АЙМАГ



Баянхонгор аймаг нь 1941 онд үүсгэн байгуулагдсан. Баянхонгор аймаг нь Монголын баруун өмнөд хэсэгт говь, хангайн, тал хээрийн 3 бүсийг хамран Алтай уулархаг нутагт оршдог. Төв нь Баянхонгор хот, Улаанбаатар хотоос 640 км зайтай. 115,977.8 км<sup>2</sup> газар нутагтай. 88,359 мянган хүн амтай. Засаг захиргааны 20 нэгжтэй. Баянхонгор аймгийн хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй 3322 иргэн байгаа нь нийт хүн амын 3.7%-ийг эзэлж байна. Тэдний 1835 нь эрэгтэйчүүд, 1095 нь эмэгтэйчүүд байна.

### БАТМӨНХИЙН ЯНЖИНДУЛАМ: ОЁДОЛ ЭСГҮҮРТ ХҮНИЙ ГАРЫН УРААС ГАДНА УХААН ШИНГЭСЭН БАЙДАГ

Батмөнх овогтой Янжиндулам нь Баянхонгор сумын Дуурсах 3 дугаар багт хүүхдийн хамт амьдардаг. Б.Янжиндулам нь 1983 онд төрсөн. Төрөлхийн сонсголын бэрхшээлтэй. Түүний ээж Н.Донжид нь удам дамжсан үйлэнд уран оёдолчин байсан нь Б.Янжиндуламын ажлын гарааг эхлүүлсэн юм. Ээж нь түүнд оёдол эсгүүрийг анх зааж сурган авьяас, ур чадварыг нь хөгжүүлэх суурийг тавьжээ.

2002 онд аймгийн Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхийн Холбоонд гишүүнээр элсэн орж хамтран ажиллаж байгаад ээжийнхээ өвлүүлсэн оёдол хийх ажлыг үргэлжлүүлэхээр 2003 онд Мэргэжил Сургалт Үйлдвэрлэлийн төвд "Оёдол, эсгүүрчин"-ий ангид элсэн орж 45 хоногийн дамжаанд суралцаж төгсөөд оёдлын цехэд ажиллаж эхэлсэн. 2003-2006 онд холбооны оёдлын цехэд оёдолчин, 2007-2018 онд "Шидэт зүү" хоршоонд оёдолчин, 2019 оноос Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв ТББ-д оёдолчноор орж ажиллаж байна. Төрөлхийн сонсголын бэрхшээлтэй ч хоршоо болон ТББ-д оёдолчноор тасралтгүй ажиллаж, 16 жилийн ажлын туршлага хуримтлуулжээ. Б.Янжиндуламын урласан бүтээл загвар сайтай, зөвхөн үндэсний хувцас төдийгүй, европ хувцсыг олон төрлөөр аймгийнхаа иргэдэд танигдсан уран, хөдөлмөрч нэгэн юм. Тэрээр оёдол эсгүүр сурах сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залууст оёдол, эсгүүрийг зааж сурган "нэг баг" болгон бүрдүүлж, 3 шавиа мэргэшүүлэн ажиллаж байна.



## УВС АЙМАГ



Увс аймаг нь Монгол улсын баруун хязгаарт Их нууруудын хотгорт оршдог, 69.6 мянган ам дөрвөлжин км нутаг дэвсгэртэй. Тус аймгийн төв нь Улаангом. Нийслэл Улаанбаатар хотоос 1336 км зайд оршино. Засаг захиргааны 19 нэгжтэй. Увс аймаг нь 2018 оны байдлаар нийт 84309 мянган хүн амтай, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 4556 хүн байгаа нь хүн амын 4.8 хувийг эзэлж байна. Тэдний 2593 нь эрэгтэй, 1963 нь эмэгтэй байна.

### АХМАД ТАМИРЧИН О.ТӨМӨРСАНАА: АЙМГИЙНХАА ШИГШЭЭ БАГИЙГ ДАСГАЛЖУУЛДАГ

Хэвлэл мэдээлэл, биеийн тамир спортын ахмад ажилчин, тамирчин О.Төмөрсанаа нь 1943 онд Увс аймгийн Хяргас суманд төрсөн. 8 нас хүртлээ өвөг, эцэг Г.Жамьянгийн гэрт өсөж, хүмүүжсэн. Хөдөөгийн бусад хүүхдүүдийн адилаар морь унаж, хонь хурга хариулах, зурам агнах зэргээр өвөө эмээдээ тусалж, бага насаа өнгөрөөсөн. Хяргас сумын бага сургуульд хоёр жил суралцсан. Багшийн туслалцаа болон өөрийнхөө хүчин чармайлтаар бичиг үсэгт бүрэн тайлагдан 1960 онд Улаанбаатарт ирж сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы хэлийг амжилттай эзэмшин суралцсан байна.



О.Төмөрсанаа нь төрөлхийн хэлгүй, дүлий боловч бичгээр ямар ч хүнтэй харилцаж, өөрийнхөө дотоод бодол, санаагаа чөлөөтэй ойлголцож чаддаг. Тэрээр 1964 онд Биеийн тамир, спортын хороонд гишүүн, 1965 онд Монголын Үйлдвэрчний эвлэлийн гишүүн, 1978 онд Монголын сонсголын бэрхшээлтэй, дүлий иргэдийн нийгэмлэгийн гишүүн, 1997 онд Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн эвлэлийн гишүүнээр тус тус элссэн. Эдгээр олон нийтийн байгууллагуудаас зохиогддог олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, нийгмийн идэвх сайтай ахмад тамирчдын нэг юм.

О.Төмөрсанаа нь 1959-1996 онуудад Хяргас сумын артельд мод бэлтгэгч, мужаан, сургуулийн галч, Цагаанхайрхан сумын сум дундын модны үйлдвэрт мод бэлтгэгч, ачигч, оосорлогч, бригадын дарга зэрэг ажлуудыг хийж эх орондоо татвар төлөгч иргэн байж, хөдөлмөр, бүтээлийн жилээ таслаагүй юм. Залуу наснаасаа үндэсний бөх болон чөлөөт бөхөөр хичээллэж, ОУ-ын нэр хүндтэй тэмцээнээс алт, мөнгөн медалиудыг эх орондоо авчирч байсан. Спортын мастер зэрэгтэй энэ хүн зөвхөн хүчний спортод өөрийгөө сорьсонгүй. Оюуны спортод нэгэн адил хүчин зүтгэсэн шатрын мастер юм. Мөн тэрээр одоо Цагаанхайрхан сумын баг, тамирчдаа дасгалжуулан оюуны болон хүчний спортын тэмцээнүүдэд бэлтгэн дасгалжуулдаг залуу хойч үедээ бахархан дуурайх баялаг намтар бүтээсэн ахмад билээ.

## ГОВЬСҮМБЭР АЙМАГ



Говьсүмбэр аймаг 1994 оны 8-р сард байгуулагдсан. Далайн түвшнээс дээш 1000-1200 метрийн өндөрт оршдог говь, тал хээр хосолсон эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг юм. 5,540 км нутаг дэвсгэртэй. Засаг захиргааны 3 сумтай. 2018 оны статистик мэдээгээр тус аймаг нийт 17796 хүн амтай. Хөгжлийн бэрхшээлтэй 729 хүн амьдран суудгаас 421 эрэгтэй, 308 эмэгтэй байна.

### И.БААТАР: **БИ ҮРГЭЛЖ ИНЭЭДЭГ БОЛСОН...**

Ичинхоролын Баатар 1960 онд төрсөн. Зоотехникч мэргэжилтэй. Мэргэжлээрээ ажиллахын хажуугаар олон төрлийн ном сонирхон уншдаг нэгэн байсан. 2001 оноос хараа нь муудаж, 2004 онд мэс засалд орсон боловч амжилтгүй болсноор бүрэн хараагүй болсон юм. Тэр цагаас хойш зургаан жилийн туршид гэртээ суусан нь түүний хувьд үнэхээр аймшигтай, инээд баяр баясгаланг мартсан он жилүүд байсан гэж тэрээр ярьдаг юм.



Инээхийг мартсан тэр жилүүдэд буюу 2008 онд Монголын хараагүйчүүдийн холбооны тэргүүн Д.Гэрэл гэж эмэгтэй Говьсүмбэр аймагт ирэхдээ хараагүй хүмүүс бариа заслын чиглэлээр сураад их амжилттай яваа тухай ярьжээ. Баатар ах үүнээс санаа аван Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгтэйгээр Улаанбаатарыг зорьж, бариа заслын сургалтад сурч төгссөн байна. Ирсэн даруйдаа ажлаа эхэлж, үйлчилгээ явуулах байрны асуудал тулгарахад орон нутгийн удирдлагууд болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартаа хандаж, дэмжлэг авснаар үйлчилгээ эрхлэх ажлын байртай болжээ.

Өдгөө тэрээр бариа заслын бүх төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж, өөрөө өөрийгөө арав гаруй жил ажлын байраар хангаж, өрхийн амьжиргаагаа нэмэгдүүлж явна. Түүний үүсгэн байгуулсан “Түмэн буян” массаж, алжаал тайлах төв өнгөрсөн хугацаанд хорь гаруй мянган иргэнд бариа заслын үйлчилгээ үзүүлжээ. Говьсүмбэр



аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үлгэр дуурайлал болсон төлөөлөл бол “Бариагч Баатар гуай” хэмээн орон нутагтаа хүндлэгдсэн Ичинхоролын Баатар юм. Тэрээр бариулсан хүн маань “Баярлалаа, баярлалаа гээд ойрхон хоёр хэлчихээр нь “Өө зүгээр дээ, зүгээр” гээд хэлэхэд л цаанаасаа баяр төрөөд явчихдаг юм. Ах нь одоо үргэлж инээдэг болсон гэлээ.

**ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХӨГЖЛИЙН  
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН  
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
САЙН ТУРШЛАГУУД**



## 1. JASS (НЭР ДЭВШСЭН) СТЕВАРТС КЕЙР БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Светарс Кейр ХХК (ИРЛАНД)

Нийгмийн үйлчилгээ/дэмжих үйлчилгээ

х.Сиобхан Кейринс, Сургалт, боловсрол, нийгмийн ентерпрайзын  
хөтөлбөрийн менежер

Stewarts, Mill Lane, Palmerstown, Dublin 20

<http://www.stewartscare.ie>



Стевартс Кейр компанийн үйлчлүүлэгчдэд дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг ханган нийлүүлэхийн тулд JASS хөтөлбөр нь хувь хүнд төвлөрсөн арга зүйг ашиглаж, үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийг хамруулан оруулдаг. Тус хөтөлбөр нь 18-аас дээш насны оюуны болон/эсвэл тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулж байна. 2000 онд анхлан эхэлснээс хойш JASS хөтөлбөрийн хүрээнд 62 үйлчлүүлэгч нь жижиглэн худалдаан салбараас эхлээд хөдөө аж ахуй хүртэл салбаруудад хөдөлмөр эрхлэх болоод байна. Тухайн ажлын байранд дээр ажиллаж буй үйлчлүүлэгч нар нь нээлттэй хөдөлмөрийн зах зээл дээр ажиллаж буй юм.



JASS хөтөлбөрийн зорилтууд нь үйлчлүүлэгч нарт ажлын байр олж өгөх, тухайн хувь хүнийг хамаарах бүлэгт хамруулан шаардлагатай зүйлсийг тогтоох, ажлын байран дээр нь дагалдан ажиллах боломжийг хангаж, ажлын байран дээрх сургалт хийж, олон нийтийн боловсролын үйл ажиллагаанд хамруулж, хараат бус амьдралын ур чадварыг хангаж, ажлын байран дээрээ дэвшихэд нь дэмжлэг үзүүлж, лекц унших, ажил олгогч нарт зориулсан сургалт хийх болон бие даан нөлөөлөл хийхийг хөхиүлэн дэмждэг.

Өмнөө тавьсан үндсэн зорилтоо хангахын тулд JASS хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээл дээр эрэл хайгуул хийж, ажлын байрыг олж тогтоон, хөдөлмөрт бэлтгэх буюу анкет, ярилцлагад бэлтгэх зэрэг үйлчилгээ үзүүлж байна. Үйлчлүүлэгч нэг бүрд хөдөлмөрийн хугацаа болон нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, орлогоо удирдах чиглэлээр зөвлөгөө өгч, ажлын байран дээрх туслах (дасгалжуулагч) нь тухайн үйлчлүүлэгчид шаардлагатай гол сургалтуудын хэрэгцээг тогтоон гаргадаг. Түүнчлэн орон нутгийн Боловсрол, сургалтын албанаас Олон нийтийн боловсролын сургалтуудыг тухайн үйлчлүүлэгчид бие даан амьдрах ур чадварыг нь хангах зорилгоор санал болгодог. Сар тутмын Ажлын байрны холбоос уулзалтыг зохион байгуулж, үйлчлүүлэгч нь өөрийн ажилтай холбоотой асуудлыг бусадтай хэлэлцэх боломжийг олгодог байна.

JASS хөтөлбөр нь Ирландын дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн холбоонд бүрэн хүлээн зөвшөөрөгдөж, тус байгууллагын ажилтнууд ч мөн холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болжээ.

## 2. KARE ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХӨТӨЛБӨР (НЭР ДЭВШСЭН) СЭТГЭЦИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ НЬ

KARE байгууллага (ИРЛАНД)  
Нийгмийн үйлчилгээ/дэмжих үйлчилгээ  
н. Кристи Линч, Гүйцэтгэх захирал  
Newbridge Industrial Estate, Newbridge., Co. Kildare, Ireland  
[www.kare.ie](http://www.kare.ie)

**KARE**

KARE хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн зорилго нь “бидний дэмжлэг үзүүлэн ажилладаг, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй, сэтгэцийн бэрхшээлтэй, насанд хүрсэн бүх хүмүүст боломжийг бий болгох” явдал юм. KARE нь сэтгэцийн бэрхшээлтэй насанд хүрсэн бүх хүнийг нийгэмшүүлэхэд хөдөлмөр эрхлэлт нь хамгийн гол зүйл хэмээн үздэг. Энэхүү хөтөлбөрөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хувь хүмүүс нь гол үйл ажиллагааг өөрсдөө удирдан явах боломжийг олгожээ. Үүний хүрээнд ямар ажил хийхийг хүсэж буй, ажиллах цаг болон авахын хүссэн цалин зэргээ өөрсдөө шийдэх боломжийг нь олгодог.

KARE хөтөлбөр нь хүмүүстэй тулж ажилладаг хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдийн багийг ажиллуулан, тухайн үйлчлүүлэгч нарт хамгийн сайн тохирох ажлын байрыг хайн олж өгдөг байна. Тухайн ажлын байрыг олж тогтоосны дараа ажлын зөвлөх (дасгалжуулагч) тухайн хүнтэй ажиллаж, сургалтын болон бусад хэрэгцээг нь тогтоож, тэрхүү ажлын байр нь ямар хэрэгцээтэй, жишээ нь тээврийн хэрэгцээ зэрэг бусад бүхий л шаардлагатай зүйлсийг олж тогтооно. Улмаар үйлчлүүлэгч болон ажил олгогчийн хэрэгцээнд үндэслэн тухайн ажил олгогчид нь мөн дэмжлэг үзүүлдэг. KARE хөтөлбөрийн энэхүү арга зүй нь цэвэр үйлчлүүлэгчид төвлөрсөн, бодит ажил, нээлттэй хөдөлмөрийн зах зээл болон бодит цалинг хөхиүлэн дэмждэг юм.



KARE хөтөлбөр нь ажлын байрыг зөвхөн нээлттэй хөдөлмөрийн зах зээлээс олох, хөдөлмөрийн гэрээг цалингийн доод хэмжээнээс бууруулалгүйгээр байгуулсан байх бодлогыг баримталдаг байна. Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс нь зөвхөн ажлын байртай болохыг баталгаажуулаад зогсохгүй KARE хөтөлбөр нь мөн дэмжлэгтэй амьжиргааны хөтөлбөрийг мөн хэрэгжүүлж байна. Энэхүү нэмэлт дэмжлэгийг KARE хөтөлбөрт хамрагдсан хүмүүст хүргэх ба энэ нь тэднийг хараат бусаар амьдрахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой хэрэгждэг. Энэхүү хөтөлбөрөөр дамжуулан KARE нь өөрийн гэсэн дэмжлэгтэй ажил эрхлэлтийн хөтөлбөрийг бий болгосон нь Ирландын баталгаажуулах үйл явцад хамрагдан, баталгаажсан байна. Өнөөдөр энэхүү хөтөлбөр нь ойролцоогоор 160 сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжин ажиллаж байна.

### 3. БОДИТ БОЛОМЖ - ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД ШИЛЖИХ НЬ (НЭР ДЭВШСЭН) **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙГ МЭРГЭЖЛИЙН ТУРШЛАГА ЭСВЭЛ ЦАЛИНТАЙ АЖЛААР ХАНГАХ НЬ**

Элит дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн байгууллага (НЭГДСЭН ВАНТ УЛС)  
Нийгмийн үйлчилгээ/дэмжих үйлчилгээ  
х. Кати Риветт, Туслах гүйцэтгэх захирал  
Unite & Magden Park, Greenmeadow, llantisant,  
Rhondda Cynon Taff, South Wales, CF72 8XT, UK  
[www.elitesea.co.uk](http://www.elitesea.co.uk)



“Бодит боломж- хөдөлмөр эрхлэлтэд шилжих нь” хэмээх үйл ажиллагааны эрхэм зорилго нь “хамтдаа ажиллах, цалинтай ажил эрхлэлтийн хүртээмжийг хангах, ажил олох, үргэлжлүүлэн удаан хугацаанд ажиллах боломжуудыг зөв зохистой дэмжлэгээр дамжуулан хангах” явдал юм. ELITE хэмээн нэрлэгдэх энэхүү хөтөлбөр нь дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн загварыг дангаар нь ашигладаг ба ажил хайгчийг дэлгэрэнгүй бүлэглэж, дараагаар нь тохирох ажлын байрыг хайж, үүн дээр шаардлагатай тохиргоог хийж, ажил олгогчтой хэлэлцээр хийж, ажлын байран дээр нь дэмжлэг үзүүлж, ажил хайгч хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зөвлөгөө өгч, тэдний эцэг эхтэй нь мөн хамтран ажилладаг. Улмаар энэхүү хөтөлбөр нь “ажилд оруулах, сургах, ажлын байранд нь үргэлжлүүлэн ажиллуулах” хэмээх загварыг ашиглаж, тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байраа удаан хугацаагаар хадгалах боломжийг нь хангах арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Хөтөлбөр нь “үе тэнгийн ментор” хэмээн нэрлэгддэг сайн дурын залуу ажилтнуудыг ажиллуулан хөтөлбөрт хамрагдаж буй хүмүүст дэмжих үйлчилгээг үзүүлж байна. Эдгээр менторууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадавхын талаарх ойлгуулах, мэдлэг бий болгох чиглэлээр ажилладаг юм. Хөтөлбөрт хамрагдаж буй хүн бүхэн өөрийн гэсэн ментортой байх ба тэд насны хувьд ойролцоо байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажлын байр олоход нь туслахын тулд ELITE хөтөлбөр нь мөн ХБИ-ийг ажиллуулж буй компаниудад сургалт явуулж байна. Хөтөлбөр нь ажил олгогч нарт зориулан ХБИ-ийн талаар мэдлэг олгох, аутизм зэрэг онцлог бэрхшээлийн тухай ойлгуулах, ажлын байран дээр тохирох хэрэглэгдэхүүнийг хэрхэн бий болгох, Тэгш эрхийн тухай хууль, болон ажилтан болон ажил олгогчид тохирсон бусад сэдвээр үнэ төлбөргүй сургалтуудыг явуулдаг. Эдгээр сургалтуудын хүрээнд ELITE нь хөгжлийн бэрхшээлтэй ажил эрхэлж буй хүмүүст тулгарч буй саад тотгоруудыг арилгаж байна.



дурын ажилтнууд нь мөн олон тооны шагнал хүртжээ.

Хөтөлбөр нь одоогоор Уэлсийн өмнөд болон баруун хэсгийг 9 мужийн 500 гаруй хүнд үйлчилгээ үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр өөрийн зорилгодоо хүрэхэд нь тэдэнд тусалж байна. ELITE хөтөлбөр нь 2007 оны нийгмийн үйлчилгээний шагнал, 2008 онд Төрийн шилдэг үйлчилгээний шагнал, 2009 онд Орон нутгийн ажил олгогчдын шагналыг хүртэж байв. Эдгээр шагналаас гадна хөтөлбөр дээр ажилласан сайн

## 4. EINER FÜR ALLE - НЭГ НЬ НИЙТИЙН ТӨЛӨӨ НЭГ НЬ НИЙТИЙН ТӨЛӨӨ - ОРОН НУТГИЙН НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДЭЛГҮҮР

Променте Стиермарк компани (АВСТРИ)  
Нийгмийн үйлчилгээ/дэмжих үйлчилгээ  
х. Анреа Зейтлингер, Гүйцэтгэх захирал  
Eisteichgasse 17, 8042 Graz, Austria  
[www.promenteteiermark.at](http://www.promenteteiermark.at)

pro mente | stmk

“Нэг нь нийтийн төлөө” хөтөлбөр нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх боломжийг “орон нутгийн нийгмийн үйлчилгээний дэлгүүрээр” дамжуулан олгохын зэрэгцээ бага орлоготой хүмүүст хэрэгцээт зүйлсээ худалдан авах, орон нутгийн хэрэглэгчдэд зориулан бараа бүтээгдэхүүнээ борлуулах, мөн Граз хотын бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн хомсдолыг мөн нөхөж өгдөг байна.

Тус хөтөлбөр нь өөрийн ажилтнуудыг хэд хэдэн шаттайгаар сургаж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээрх өөрийн зорилгодоо хүрэхэд бэлэн болдог байна. Сургалтад хамрагдсан ажилтнуудад хоёр сургагч шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлдэг. Сургагч нар нь ажил эрхлэгч нарт өөрсдийн харилцааны чадварыг хөгжүүлэх болон зөөлөн ур чадварыг нь хөгжүүлэх эрчимтэй сургалтад хамруулдаг. Түүнчлэн ажил эрхэлж



буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд зохион байгуулалт, хараат бус амьдрал, өөрийн үйл ажиллагаанд хариуцлага хүлээх, сэдэлжүүлэх чадвар зэрэг хувийн ур чадваруудаа хөгжүүлж байдаг. Ажил эрхлэгчдийн гүйцэтгэлийн шаардлагуудыг, сургагч нарын зүгээс өгсөн санал дээр үндэслэн бага багаар нэмэгдүүлж байдаг.

Зах зээл нь ажил эрхэлж буй хүмүүст зориулан бүлгээр болон бие даан ажиллах орчныг бий болгоно. Бүлгээр ажиллах орчин нь бага сургуульд олсон мэдлэгийг бататгах, сургалт болон харилцааны ур чадвар, жижиглэн худалдааны чадвар зэргээ байнга нэмэгдүүлэх боломжийг хангана. Хувь хүний орчин нь гэрээгээр заасан гүйцэтгэх ажлын үндэс, ажил мэргэжлийн зөвлөгөө, тогтвортой байдлын шинжилгээ, онолын болон практик түвшний давуу болон сул талуудыг тогтоох, түнш компаниуд дээр дагалдан хэлбэрээр ажиллах боломжийг хангана.

2008 оноос эхлэн Нэг нь нийтийн төлөө хөтөлбөр нь нийт 65 оролцогчдод үр шимээ хүртээжээ. Дунджаар оролцогчдын 43% нь нээлттэй хөдөлмөрийн зах зээл дээрээс ажлын байртай болжээ. Түүнчлэн нийт оролцогчдын 26% нь бусад төслүүдэд хамрагдсан байна.

## 5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙГ АЖИЛ ХӨДӨЛМӨРТ ОРОЛЦУУЛАХ НЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ ДИЗАЙН

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүтээлч боловсролын төв (СЕРБИ)  
Нийгмийн үйлчилгээ/ Дэмжлэг  
х.Маргарета Кечман, ТУЗ-ийн Дарга  
Kraljevica Marka 4, Belgrade, Serbia  
[www.kec.org.rs](http://www.kec.org.rs)



2002 онд анхлан эхлэн хэрэгжсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажил хөдөлмөрт оролцуулах хөтөлбөр (КЕС) нь өсөлт хөгжлийн насан дээрээ яваа, төрөл бүрийн асуудлуудтай нүүр тулгарч буй хөгжлийн бэрхшээлтэй залуусыг тулгарч буй бэрхшээлээ даван туулах, олон нийттэй түншлэл үүсгэж, өөрийн давуу талууд, авьяас болон чадамжийн нээн илрүүлэхэд нь туслах хөтөлбөрийг боловсруулан гаргах зорилготой.



КЕС хөтөлбөр нь 4 хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр нь: өдрийн үйлчилгээний төв, ажилд зуучлах, нийгмийн энтерпрайз болон нөлөөлөл, сургалт юм. 1. Өдрийн үйлчилгээний төв нь хараат бус байдлыг дэмжин идэвхжүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагааг явуулдаг. 2. Ажилд зуучлах хөтөлбөр нь төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан хөдөлмөр эрхлэлтийн олон янзын загварыг боловсруулах, хэрэгжүүлэх зорилготой. 3. КЕС хөтөлбөр нь

нийгмийн энтерпрайзаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг. Эдгээр байгууллага (ентерпрайзууд) нь гэрийн тэжээмэл амьтны хүнс үйлдвэрлэх, модны үрсэлгээ бэлтгэх, жимсний ороомог үйлдвэрлэх зэрэг ажил эрхэлж байна. 4. КЕС нь хууль тогтоомж, журмуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байрыг хангахад нь эергээр нөлөөлөх сургалт болон нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Түүнчлэн КЕС нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлэх хүсэлтэй мэргэжилтнүүдэд зориулан сургалт явуулдаг.

КЕС хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нээлттэй хөдөлмөрийн зах зээл дээр ажлын байр олж, нийгэмшсэн, хараат бус, идэвхтэй амьдрах боломжийг ханган өгч байна. КЕС хөтөлбөрийн гаргасан загвар нь хөтөлбөрт хамрагдаж буй хүмүүс болон иргэдийн хооронд шууд холбоо бий болгож, илүү нэгдсэн, уялдсан нийгмийг

бий болгох зорилгоор тулгараад буй саад тоггор, хэвшмэл тогтсон үзлийг бууруулдаг. Түүнчлэн төсөлд хамрагдаж буй хүмүүсийн авч буй цалин урамшууллын шударга хэмжээ нь тэдний санхүүгийн хараат бус байдлыг нэмэгдүүлж байдаг.

КЕС- Ажил хөдөлмөрт оролцуулах хөтөлбөр нь 2004 онд зөвхөн нэг л компани дээр эхэлсэн бол өнөөдөр тус хөтөлбөрийн хүрээнд 30 гаруй компани, 160 орчим үйлчлүүлэгч хамрагдаж байна. Мөн одоогоор хөтөлбөрт хамрагдаж буй 45 хүн бүрэн хэмжээнд ажил эрхэлж буй хэмээх статустай болж, тэдгээрийн олонх нь Ажил хөдөлмөрт оролцуулах хөтөлбөрт хамрагдаж байна.

КЕС нь Эрсте сангийн Нийгмийн инновацийн шагналд гуравдугаар байрт шалгарсны зэрэгцээ Сербийн Засгийн газрын зүгээс тус хөтөлбөрт магадлан итгэмжлэл олгожээ.



*Талдгал*

Blank lined area for writing, consisting of 20 horizontal dotted lines.

Түгээгдэл

Blank lined area for writing answers, consisting of multiple horizontal lines.